

## ЭДИЙН ЗАСГИЙН КОРРИДОРЫН ХҮРЭЭНД “ХЯТАД-МОНГОЛ-ОХУ”-ЫН ГУРВАН ТАЛТ ХУДАЛДААНЫ БОДЛОГЫГ УЯЛДУУЛАХ БОЛОМЖ

С.Энхцэцэг\*

***Abstract:** The paper focuses on possibilities to coordinate the trilateral trade policy engagement among China, Mongolia and Russia in the framework of the economic corridor. There is a big gap in their economic structure and trading policy options to connect it closely and effectively based on their different development stages. Mongolia is considered a landlocked country with a small, fragile economy. China, Russia are main trading countries around the world and both of them have trade policy system to tax deduction policy (including lists of non-negotiable goods) for the least developing countries with natural resources. It is possible that China and Russia can make the decision to free imports of finished goods by the processing of raw materials and minerals in Mongolia in reality.*

***Key words:** Trilateral trade policy, to tax deduction from the importing goods, Mongolia, Russia and China*

\*\*\*

БНХАУ, ОХУ хоёулаа НҮБ-ын гишүүн, ДХБ-ын гишүүн билээ. Олон улсын худалдааны эрх зүйн тогтолцоог тарифын хөнгөлөлт талаас нь авч үзвэл НҮБ-ын Худалдаа, Хөгжлийн Байгууллагын 1968 оны тогтоол, Дэлхийн Худалдааны Байгууллага (ДХБ)-ын суурь болсон Тарифын Ерөнхий Хэлэлцээр(GATT)-ийн 1971 оны шийдвэр зэрэгт далайд гарцгүй хөгжиж буй орнуудад зориулж тарифын хөнгөлөлтийн нэгдсэн систем (GSP), түүний дотор бүр тусгайлан тэг хүртэл хөнгөрүүлсэн тарифын зохицуулалт хийх заалт оруулж, хөнгөлөлт үзүүлж байхыг өөрсдийн гишүүн орнуудад хүсэмжилсэн байх юм. Олон улсын конвенц, хэлэлцээрээс анзаарууштай нэгэн чухал зүйл бол тарифын хөнгөлөлт үзүүлэгч орон нь хөнгөлөлт хүртэгч орны зүгээс аливаа урьдчилсан нөхцөл, үүрэг амлалт шаардахгүй байх, холбогдох орнууд хоёр талаар тохиролцох зэрэг зарчмыг тогтоосонд оршиж байна. Эдгээр шийдвэрийг хууль зүйн үндэстэй болгоход ДХБ-ын шийдвэр маш чухал байдаг ажээ. Учир нь ДХБ-ын шийдвэрийг гишүүн орнууд заавал хэрэгжүүлэх үүрэгтэй эс биелүүлбэл төлөөс торгуулиас эхлээд хариуцлага, хориг, хязгаарлалтын арга хэмжээ яригддаг байна. **Дэлхийн Худалдааны Байгууллагын хүрээний Тарифын Ерөнхий Хэлэлцээр(GATT) ийн 1979 оны 11 дүгээр сарын 28-ны шийдвэрээр хэлэлцээрт “Боломж Олгох” Заалт зүйл (Enabling Clause) оруулж, хөгжиж буй орнуудыг тарифын хөнгөлөлтийн тогтолцоонд аль болох бүрэн хамааруулах боломжийг эрх зүйн**

\* МУИС, ОУХНУС-ын ОУХ-ны тэнхимийн дэд проф, Доктор (Ph.D) enkhsetseg@num.edu.mn

хувьд баталгаажуулсан байдаг. Чингэхдээ хэлэлцэн тохирогч талууд хөгжиж буй нөгөө орныхоо эдийн засгийн хөгжилд аль болох тааламжтай орчин бүрдүүлэх, түүний тулд Үндэсний Нэн Тааламж(MFN)-тай нөхцлийн хүрээнд олгодог тарифаас ч бууруулж болохын хамт мөн харилцан үүрэг хүлээж болохыг орнуудад зөвшөөрсөн байдаг. Үндэсний нэн тааламжтай нөхцлийг БНХАУ, ОХУ манай улсад олгодог гэж ойлгож байна. **Үүнээс хөнгөрүүлж тэглэх хувилбарын тухай гол нь ярих учиртай болно.** НҮБ болон Дэлхийн Худалдааны байгууллага болон өндөр хөгжилтэй орнууд Тарифын Хөнгөлөлтийн Систем(GSP), түүн дээр тарифын тэг хувилбарыг ихэвчлэн “**нэн ядуу**” орнуудад өгнө гэдэг ерөнхий зарчмыг барьдаг **ч гэсэн амьдрал дээр хөнгөлөлт авах орнуудын нөхцөл байдлаас хамааран нэн бага орлоготойгоос гадна багахан орлоготой, хөгжлийн анхан шатанд буй орнуудад тэг татварын горимыг бүрдүүлж болох юм.**

**ДХБ-ын эрх зүйн орчинд орсон бас нэг томоохон өөрчлөлт бол хөгжиж буй орнууд өөр хоорондоо болон өөрсдийн үзэмжээр буурай хөгжилтэй бусад хөгжиж орнуудад гаалийн тарифын хөнгөлөлт, чөлөөлөлтийг олгож болохыг ДХБ-ын (WT/L759)-шийдвэрээр баталгаажуулсан байна.** Энэ заалтыг удирдлага болгон БНХАУ, Энэтхэг, Өмнөт Солонгос зэрэг хөгжиж буй орнууд тарифын хөнгөлөлтийг бусад орнуудад олгож эхэлсэн байна. Жишээ нь БНХАУ гэхэд 40 шахам хөгжиж орнуудад татварын тэг хувилбарыг олгосон байна. Өөрөөр хэлбэл БНХАУ эдгээр орнуудын бараанд гаалийн татвар ногдуулахгүйгээр өөрийн улсдаа оруулж буй хэрэг. Хөнгөлөлтөд хамрах орны хүрээний талаар ДХБ-ын Зарга Шийдэх байгууллагын 2004 оны тайлбар(Эрх зүйн баримт бичиг гэсэн үг) байдаг байна. Үүгээр татварын нийтлэг хөнгөлөлтөд хамаардаг орнуудаас гаралтай бүтээгдэхүүнд ДХБ-ын гишүүн орнууд тарифын тал бүрийн хөнгөлөлт үзүүлж болно гэсэн тайлбар хийжээ. Мөн ДХБ-ын аль нэг гишүүн өөрийн хүсэлтээр нийтлэг хөнгөлөлтийн систем(GSP)-ийн хүрээнд “хөгжиж буй орнуудын **хөгжих зайлшгүй (Хятадуудын яриад байгаа хамтдаа хөгжих, Оросуудын монголын мал аж ахуйг дэмжих)** шаардлагыг тодорхойлсны үндсэн дээр татварын илүүтэй хөнгөлөлт үзүүлэх замаар дэмжиж болно” гэжээ. Энэхүү тайлбарыг үндэслэн зарим орнууд, тухайлбал Европын Холбоо дэлхий дахины асуудалд болсон **ядуурлыг**(Монголын албан ёсны статистик хүн амын 30 хувь нь нэн ядуу) бууруулах зорилт бүхий GSP-г санаачлан, гаалийн татварыг чөлөөлөх замаар хөгжиж буй орны гадаад худалдааны орлогыг нэмэгдүүлэх, тогтвортой өсөлт, сайн засаглалыг дэмжих талаар тохирсон орнуудад гаальгүйгээр бараа оруулах горим тогтоож эхэлсэн. Үүнд Монгол, Шри-Ланк эхлэн хамаарч байсан юм.

1968 онд Шинэ Дели хотноо НҮБ-ын Худалдаа, Хөгжлийн бага хурлын 21-р тогтоол батлагдсан бөгөөд түүнд зааснаар, “бүгд нэг зорилготойгоор хөгжиж буй орнуудад тааламжтай тэр дундаа нэн буурай хөгжилтэй улс орнуудад зориулсан тусгай зохицуулалт бүхий харилцан адилгүй, ялгаварлан гадуурхалтгүй хөнгөлөлтийн систем бий болгохдоо

a/ экспортын орлогыг нэмэгдүүлэх;

- б/ аж үйлдвэржилтийг дэмжих;
- в/ эдийн засгийн өсөлтийг хурдасгахыг чухалчилан үзсэн байна.

1970 оны 10-р сард НҮБ-ын Худалдаа, Хөгжлийн бага хурал (UNCTAD) –ын Худалдаа, Хөгжлийн Зөвлөлөөс Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн үзэл баримтлалыг хөгжүүлэхээр нэгдсэн шийдвэрийг баталсан бөгөөд Үүнд: “тарифын хөнгөлөлт эдлэх эрх зүйн статусаар хөнгөлөлт олгох улс орон тус бүрээс хөнгөлөлт эдлэх эрх улс орнуудад олгоход тус тус дараах зүйлээр зохицуулагдана;

- (а) Түр хугацаатай тарифын хөнгөлөлт;
- (б) Хөнгөлөлт олгох нөхцөл нь заавал дагаж мөрдөх үүрэг амлалт үүсгэхгүй, ямар нэг байдлаар урьдчилан сэргийлэх нөхцөлгүй;
  - Бүхэлд нь болон хэсэгчлэн гаалийн тарифаас чөлөөлөх;
  - Нэн тааламжтай үндэслэлээр тарифыг бууруулах;
- (с) Хөнгөлөлт олгох нөхцөл нь олон улсын өмнө хүлээсэн үүрэг амлалтын хувьд шаардлагатай бол үүргээс чөлөөлөх нөхцөлтэй байна, тухайлбал Тариф Худалдааны Ерөнхий Хэлэлцээрт; ТХЕХ-ийн дүрмийн үндсэн хэсэгт Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн хөнгөлөлтийн нөхцлүүдийг нэгэнт багтаахын тулд гэрээнд оролцогч талууд 1979 оны зөвшөөрөл бүхий нэмэлт дүрэм болох Эрх олгох нөхцөл (Ялгавартай ба илүү таатай нөхцөл, харилцан таатай нөхцөл болон хөгжиж буй орнуудын хамтын оролцооны талаар 1979 оны 11-р сарын 28-ны шийдвэр) –ийг батласан бөгөөд хөгжиж буй орнуудын эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулахын тулд үндэсний нэн тааламжтай хөнгөлөлтийн нөхцлөөс (MFN) тодорхойгүй хугацаагаар татгалзах; хэмээн тусгагджээ.

Сүүлийн 40 жилийн хугацаанд Хөнгөлөлтийн Ерөнхий Системийг хэрэгжүүлэх үндсэн гурван зарчмыг 21-р тогтоолд нарийн тусгасан ч бүр эхнээс нь чанд мөрдөөгүй, цаг хугацаа өнгөрөх тусам ялгаатай байдал нь улам бүр нэмэгдсээр байна. Тухайлбал, **нэгдүгээр зарчмаар** хөгжиж буй бүх орнуудад хөнгөлөлт олгох эрх бүхий бүх улс орнуудын зүгээс хэрэглэгдэх хамтын хөтөлбөрийг дэвшүүлсэн. Үнэн хэрэгтээ бараа бүтээгдэхүүний хамрах хүрээ, тарифыг бууруулах ойлголт, гарал үүслийн тухай журам, баталгааны тал дээр янз бүрийн Хөнгөлөлтийн Ерөнхий системийн хөтөлбөрүүдийн хооронд ихээхэн ялгаатай байна. Тиймээс зохицуулалтын тодорхой түвшинд бараа бүтээгдэхүүний хамрах цар хүрээг тогтоож, зарим нэг хөтөлбөрүүдээс нэхмэл эдлэл болон хувцас хунар үйлдвэрлэх салбарыг бүр мөсөн хасах шаардлагатай.

Гарал үүслийн хувьд Хөнгөлөлтийн Ерөнхий системийн хөтөлбөр (GSP scheme) тус бүрд гарал үүслийн шалгуур болон нэмэлт шаардлагуудыг тогтоох шаардлагатай. Хоёр дахь зарчим ёсоор харилцан адилгүй байх гэдэг нь хөнгөлөлт

эдлэгч улс орнуудад адил хэмжээний хөнгөлөлт олгохгүйгээр үүний оронд Хөнгөлөлтийн Ерөнхий системийн хөнгөлөлт эдлэх статус олгогдох болсон. Гэвч хөнгөлөлт олгогч тодорхой улс орнуудад сонгох эрх болон зарим тохиолдолд шууд бусаар хөнгөлөлтийг зогсоох эрхийг олгожээ. Гуравдугаар зарчим ёсоор ялгаварлахгүй байх гэдэг нь хөгжиж буй бүх улс орнууд хөтөлбөрт адил тэгш байдлаар хамрагдах болон бусад орны зүгээс ийм байдлаар хандах шаардлагатай. Үүний үр дүнд хөнгөлөлт эдлэгч улс орнуудын хооронд тодорхой зааг ялгааг тогтоох нь эдийн засаг, хөгжлийн хувьд онцгой шаардлага бүхий улс орнуудын ангилалд багтсан нэн буурай хөгжилтэй орнуудад зориулсан тусгай зохицуулалтыг оруулах боломжтой болсон.

Дэлхийн хэмжээнд ядуурлыг бууруулах арга хэрэгсэл болгохын тулд олон улсын зах зээлд ХБО-ийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2000 оны Мянганы Тунхаглалд зах зээлд татвар, квотгүй зах зээлд нэвтрэх эрхтэй байхаар тохиролцсон. 2000 онд Мянганы тунхаглалд үүнийг хүлээн зөвшөөрснөөс хойш ХБО-ын зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэхэд ихээхэн ахиц дэвшил гарсан боловч хамгаалалтгүй хэвээр байна. Хонконгд болсон 2005 оны ДХБ-ын Сайд нарын зургаадугаар Бага хурлаар хөгжингүй гишүүн орнууд хоорондоо бүтээгдэхүүнээ гаалийн татваргүй, квотгүй худалдах тохиролцоонд хүрсэн. Мөн 2008 онд дараагийн ДХБ-ын сайд нарын хурлаар зах зээлд нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх амлалт өгсөн. НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал нь ДХБ-ын хэлэлцээрээр хөгжиж буй орнуудад дэмжлэг үзүүлсээр ирсэн бөгөөд татвар болон квотын хөнгөлөлт зэрэг асуудлаар туслалцаа үзүүлсээр ирсэн. Хонгконгийн энэхүү шийдвэрийг баталснаас хойш гишүүд ХБО-уудын бүтээгдэхүүнийг татвар, квотгүйгээр зах зээлд нэвтрэхэд ахиц гарсан. Бараг бүх хөгжингүй гишүүн орнууд татвар, квотын хязгаарлалтгүйгээр ХБО-уудын барааг зах зээлдээ нэвтрүүлжээ.

2004 онд Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн хүрээнд ДХБ болон Энэтхэг улсын хооронд Эрх олгох нөхцлийн асуудлаар маргаан дэгдэж Давж Заалдах Шатны Байгууллагын тогтоосноор зарчмын хувьд ДХБ-ын гишүүн улс өөр өөр гарал үүсэлтэй бүтээгдэхүүний хувьд ялгаатай гаалийн тарифын хөнгөлөлт эдлэх бөгөөд ижил нөхцөл байдалтай ХЕС-ийн хөнгөлөлт эдлэгч бүх улсуудад тохирох адил зохицуулалтын нөхцөл үйлчлэхээр болсон. ДХБ-ын гишүүн оронд ХЕС-ийн хөтөлбөрийн хүрээнд тарифын нэмэлт хөнгөлөлт олгохын тулд хөгжиж буй орнуудын хөгжлийн тусгай хэрэгцээ шаардлага болох тарифын хөнгөлөлтөөс илүү үр ашгийг хүртэх бодитой үндэслэлийг тогтоох шаардлагатай байна. Уг үндэслэлээр Эрх олгох нөхцөл нь “ тогтвортой хөгжил, сайн засаглалыг дэмжих, олон улсын худалдаагаар ашиг олж байгаа хөгжиж буй орнуудад ядуурлыг бууруулахад хувь нэмрээ оруулах” гэсэн нь Европын Холбооны Тарифын Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн зорилгоос урган гарчээ. Эндээс үзвэл ЕХ-ны ХЕС-ийн ашиглалтыг сайжруулах чадвараа хөгжүүлэх нь улам чухлаар тавигдаж байна.

Худалдааны хөнгөлөлтийг бий болгох чиглэлээр сүүлийн үеийн баримт бичиг нь Дэлхийн Худалдааны Байгууллагын гишүүд 2013 оны 12-р сард хийсэн Худалдааны

дэмжлэг үзүүлэх хэлэлцээр юм. Гишүүдийн гуравны хоёр нь соёрхон батласнаар хүчин төгөлдөр болсон хэлэлцээр үндсэн хоёр хэсэг, эцсийн заалтууд болон хавсралтуудаас бүрдэнэ. Эхний хэсэг нь худалдааг хөнгөвчлөх талаарх 10 зүйл, гаалийн хамтын ажиллагааны тухай 1 зүйл, байгууллагын зохион байгуулалтын тухай 1 зүйлээс бүрдсэн. Хоёр дахь хэсэгт хөгжиж буй болон буурай орнуудын онцгой, ялгаатай талуудыг авч үздэг. Ерөнхийдөө ядуурлыг эрс бууруулж эдийн засгийн өндөр өсөлтийг тогтвортой байлгаж чадсан улс орнууд түүхий эдийн хараат байдал, хөгжил дорой байдлаас салсан юм. Энэ нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэх, экспортлох зэрэг эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг бий болгох замаар эдийн засгаа төрөлжүүлэх боломжтой болдог. Мөн уг хэлэлцээрээр ХБО-уудад зориулсан татвар, квотын хязгаарлалтгүйгээр барааны худалдааны зохицуулалтын хамрах хүрээг нэмэгдүүлэхийн тулд хөгжингүй орнууд дэмжлэг үзүүлэх шийдвэрийн төсөл боловсруулж ХБО-уудын худалдаанд оролцох боломжийг нэмэгдүүлэхийг чармайжээ. Сайд нарын бага хурлаар ХБО-ын талаар дараах 4 үндсэн асуудлыг хамруулжээ. Үүнд:

- Татваргүй, квотгүй зах зээлийг бий болгох тухай шийдвэр
- Хөгжил буурай орнуудын хөнгөлөлттэй дүрмийн шийдвэр
- Хөгжил буурай орнуудын үйлчилгээнээс татгалзах тухай шийдвэрийг эргэн харах
- Хөвөн даавууны бүсэд худалдааны болон хөгжлийн туслалцааны асуудлыг хамарсан шийдвэр

Нэн буурай хөгжилтэй орнууд нь дэлхийн хамтын нийгэмлэгийн ядуу гишүүд юм. Мөн дэлхийн хүн амын 12 орчим хувийг эзэлдэг боловч дэлхийн ДНБ-ний 2-оос бага хувийг эзэлдэг ба дэлхийн худалдааны нийт бүтээгдэхүүний 1 орчим хувийг эзэлдэг. Дэлхийн худалдаанд тун бага оролцдог. (НБХО-ын жагсаалт үзнэ үү.) ДХБ-ын сайд нарын зөвлөлийн бага хурлаар хэлэлцэн батласан шийдвэр юм. Уг шийдвэр нь дэлхийн зах зээлийн үйлчилгээний худалдаанд ХБО-ын оролцоог нэмэгдүүлэх, хөгжлийн зорилгодоо хүрэхэд туслах агуулгатай. ХБО-уудын импортод хамаарах гарал үүслийн тухай хөнгөлөлттэй дүрмийн төслийг Балид ДХБ-ын Сайд нарын бага хуралд өргөн барьсан. ХБО-нуудын экспортыг хялбарчлах боломжтой болно. Гарал үүслийн тухай дүрэм нь бүтээгдэхүүн хаанаас гарал, үүсэлтэй болохыг тодорхойлох шалгуур бөгөөд татвартай бүтээгдэхүүнээс ашиг олохын тулд хэрэглэдэг. Гарал үүслийн хөнгөлөлттэй дүрэм, холбогдох баримт бичигт тавигдах шаардлага нь аль болох ил тод, энгийн байхыг чухалчилж, ДХБ-ын холбогдох байгууллагууд жил бүр эдгээр гарал үүслийн дүрмийг хянан шалгадаг.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага болон өндөр хөгжилтэй хөгжиж буй орнуудын өндөр орлоготой гишүүн орнууд хөгжиж буй орнуудад зах зээлд хөнгөлттэй нэвтрэх боломжийг олгодог боловч ХБО-

ын эдийн засгийн бүтцээс үүдэлтэй эмзэг байдал улам бүр нэмэгдэж байгаа тул хөгжингүй орнууд тарифын 97 хувийг тэглэж ХБО-дад импортийн татвар, квотын хязгаарлалтгүй нэвтрэх боломжыг олгохыг зөвшөөрсөн. Дэлхийн худалдааны байгууллага Дохагийн үе шатны хэлэлцээрийн хүрээнд 2005 оны 12-р сарын Хонконгийн сайд нарийн уулзалтын үеэр хамгийн буурай хөгжилтэй улс орнуудын 97%-ийг татвараас чөлөөлж, квотгүй чөлөөтэй нэвтрүүлэхийн зөвшөөрсөн<sup>2</sup>. ХБО-ууд тарифын 3% ХБО-ын экспортын хувь хэмжээнд дорвитой нөлөөлж чадна хэмээн 100% хүртэл чөлөөлөхийг хүсч байгаа юм.

Нэн буурай хөгжилтэй орны бүтээгдэхүүн хөгжиж буй зах зээлд борлуулах тоо хэмжээ хязгаарлагдмал байгаа явдал юм. Хөгжингүй зах зээлд нэтрэх хүрээ хязгаарлагдмал байдаг. Гиймээс 2015 оны 9-р сарын 23-нд Худалдаа Хөгжлийн хуралдаан дээр АНУ-ын төлөөлөгчид нэн буурай хөгжилтэй орнуудад бүтээгдэхүүний тооноос хамаарах тарифын 5 шугамыг арилгахад шаардагдах хууль эрх зүйн алхмуудыг хийсэн байна. Нэн буурай хөгжилтэй орнуудын бүтээгдэхүүнийг татваргүй, квотгүй зах зээлд нэвтрэх боломжийг байнга нэмэгдүүлж байна.

Балигийн бага хурлаар татваргүй, квотгүй шийдвэр гаргахдаа: “Тарифын түвшинд тодорхойлсон нэн буурай хөгжилтэй орнуудад 97 хувиас багагүй татваргүй, төлбөргүй квотгүй зах зээлд нэвтрэх боломжийг хөгжингүй орнуудын зүгээс олгох, нэн буурай хөгжилтэй орнуудын зах зээлд нэвтрэх боломжийг улам бүр нэмэгдүүлэхийн тулд эдгээр бүтээгдэхүүнийг гаалийн татвараас чөлөөлөх, квотыг чөлөөлөх байдлыг сайжруулахыг эрмэлзэнэ” гэжээ. Хөгжиж буй гишүүд, тухайлбал: Чили, Хятад, Энэтхэг, Солонгос, БНХАУ-ын Тайпэй, Тайланд улсууд өөрсдийн татвар, квотгүй системийг ДХБ-д мэдэгдэв. Эдгээр гишүүдийн зарим нь нэн буурай хөгжилтэй орнуудад (НБХО) өргөн хүрээний хөнгөлөлттэй татваргүй, квотгүй нэвтрэх боломжийг олгодог. Үүнээс гадна хөгжиж буй 3 гишүүн улс (Киргиз, Тажикстан, Турк) татваргүй квотгүй зах зээлд нэвтрэх боломжийг санал болгодог.

### Түнш орнуудын нэн буурай хөгжилтэй орнуудад үзүүлдэг татваргүй, квотгүй систем

Түнш орнууд	Хөнгөлөлтэй татварын дундаж (гол үзүүлэлтүүд)	Татвар ногдуулах шугамын тоо (үндэсний тарифын шугам)	Мэдээллийн лавлагаа
БНХАУ (2014)	94.9% (ХАА-н бүтээгдэхүүн, химийн бодисууд, машин, цаас, модон эдлэл, хөвөн, арьс)	673	WT/COMTD/N/39 and WT/COMTD/N/39/Add.1/Rev.1

<sup>2</sup> Duty-Free and Quota-Free (DFQF) market access for Least Developed Countries, WT/COMTD/W/214. Nov.9.2015

БНСУ	90.3% (мах, загас, хүнсний ногоо, хүнсний бүтээгдэхүүн)	1185	WT/COMTD/N/12/Rev.1 and WT/COMTD/N/12/Rev.1/Add.1
ЕХ	99.0% (зэвсэг, сум)	91	WT/COMTD/N/12/Rev.1/Add.2, WT/COMTD/N/12/Rev.1/Add.4
Япон Улс (2014)	97.9% (цагаан будаа, элсэн чихэр, загасан бүтээгдэхүүн, арьсан эдлэл)	197	WT/COMTD/N/12/Rev.1/Add.14 WT/COMTD/N/12/Rev.1/Add.15
ОХУ (2014)	36.3% (нефьт, зэс, төмрийн хүдэр, савхин эдлэл, хувцас, хувцасны хэрэглэл)	7415	WT/COMTD/N/42
АНУ	82.6% (сүүн бүтээгдэхүүн, чихэр, какао, арьс ширэн эдлэл, хөвөн, хувцас, хувцасны эдлэл, нэхмэл, нэхмэл эдлэл, гутал, цаг)	1862	WT/COMTD/N/1/Add.7 WT/COMTD/N/1/Add.8

Эх сурвалж: Duty-Free and Quota-Free (DFQF) market access for Least Developed Countries, WT/COMTD/W/214. Nov.9.2015 p.3

Дээрх хүснэгтээс үзвэл ЕХ нэн буурай хөгжилтэй орнуудад импортын татварыг 99% хүртэл хамгийн өндөр тогтоосон бол ОХУ 36,3 хувийн татвараар хамгийн багаар тогтоожээ. Манай гадаад худалдаанд гол жин дардаг 6 улсын татварыг авч үзэхэд БНХАУ, БНСУ, Япон, ЕХ зэрэг 4 улс 90 дээш хувиар хөнгөлж, АНУ 1862 нэр төрлийн бараанд 82,6 хувийн татварын хөнгөлөлт үзүүлэхээр байна. Харин ОХУ-ын хувьд хамгийн их буюу 7415 нэр төрлийн бүтээгдэхүүнд 36,3 хувийн татвар хөнгөлөхөөр байна. Газрын тос, зэс, төмөр, хүдэр, савхин эдлэл, хувцас зэрэг манай голлох экспортын бараанд ногдуулахаар харагдаж байна. ЕХ цөөхөн нэр төрлийн бүтээгдэхүүнд хамгийн өндөр татварын хөнгөлөлт үзүүлэхээр байна.

Мөн зарим барааны экспортын тарифыг багасгах төдийгүй цөөн тооны бараа бүтээгдэхүүний импортын тарифын хэмжээг түр зуур тэглэх болсноо БНХАУ-ын сангийн яамнаас мэдэгдсэн байна. “Түр зуурын” татварын хувь хэмжээг мэдэгдэхүйцээр өөрчлөх боломж байгаа бөгөөд одоогийн байдлаар илүү давуу эрхтэй орнуудын стандартын хэмжээнээс багасгаж болох боломжийг эрэлхийлж байгаа төдийгүй энэ бүх нөхцөл нь ДХБ-ын бүх гишүүн орны хувьд хэрэгжих боломжтой юм. АНУ-ын нийт экспортын хэмжээ нь АНУ-Хятадын худалдааны дайнаар тогтоогдсон тарифын нөлөөнөөс хамааралтай байгаа бөгөөд АНУ-ын экспортын хэмжээ хоёр орны хоорондох яриа хэлэлцээ амжилтанд хүрэх

хүртэл ихэнх бүтээгдэхүүн нь хариу арга хэмжээний хүрээндэх тарифаар зохицуулагдсанаар АНУ-ын экспортоос хүртэх ашгийн хэмжээ буурах төлөвтэй байна. АНУ-ын шар буурцаг болон малын тэжээлийн гол эх үүсвэрээр ашиглагдах хүнсний бүтээгдэхүүний тарифыг зогсоох төдийгүй мөн Хятад улс наран цэцэг болон канола зэрэг төрөл бүрийн хүнсний бүтээгдэхүүний импортын тарифыг тэглэх болсон байна. Эмийн үйлдвэрлэлд ашиглагддаг зарим материалыг тэг тарифаар тооцож байгаа бөгөөд мөн өндөр технологийн бүтээгдэхүүний импортод ногдуулах татварыг “харьцангуй бага” байхаар зохицуулж байна, тухайлбал агаарын хөлгийн генераторын хувьд 1%, машины угсралтын шугамд ашигладаг гагнуурын роботын хувьд 5%-ын татвартай байхаар тогтоосон байна. Тус яам нь 2018 оны 7-р сарын 1-нээс эхлэн эмнэлгийн оношлогооны машин, чанга яригч, принтер зэрэг өргөн хүрээнд ашиглагдах мэдээллийн технологийн бараануудын импортын тарифыг хамгийн бага байхаар зохицуулсан байна. Хятад улс 2019 оны эхнээс эхлэн бордоо, төмрийн хүдэр, чулуун нүүрсний давирхай, модны целлюлоз бүтээгдэхүүний экспортын тарифыг 94 хувиар нэмнэ. Одоогийн байдлаар эдгээр барааны экспортын тариф 40 хувьтай байгаа юм.

### **“Нэг бүс нэг зам”-ын хүрээн дэх эдийн засгийн коридорын хамтын ажиллагаа**

Монгол улс БНХАУ-ын Дарга Ши Жин Пиний 2013 оны 9 дүгээр сард санаачилсан “Нэг бүс, нэг зам” санаачилгад хамрагдан, хамтарч ажиллах болсон. Гурван улсын эдийн засгийн коридор бол ЕАЭЗХ, Торгоны замын нэг зам, бүслүүр, Монголын “Хөгжлийн зам” хөтөлбөрийн интеграцийг хэрэгжүүлж, хоршин хөгжих явдалд үндэслэгдсэн байна. Энэ хүрээнд 2017 оны 8 дугаар сард Москвад зохиогдсон гурван улсын шинжээчдийн түвшний II уулзалт чухал үе шат болов. Тус уулзалтаар Монгол Улсын ГХЯ, ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн яам, БНХАУ-ын Хөгжил шинэчлэлийн хороо хооронд Монгол, Орос, Хятадын “Эдийн засгийн коридор”-ын хэрэгжилтийг урагшлуулах хамтарсан механизм байгуулах тухай “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн агуулгыг тохиролцож, гарын үсэг зурж, талууд “Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-т тусгагдсан 32 төслөөс тэргүүлэх ач холбогдол өгч эхний ээлжид хэрэгжүүлэх төслүүдийн талаар хэлэлцэж, *нэгд*, төмөр замын төв коридор, *хоёрт*, авто замын төв коридор байгуулах, *гуравт*, Монгол, Оросын цахилгаан эрчим хүчний сүлжээг шинэчлэхэд Хятадын аж ахуйн нэгжүүд оролцох боломжийг судлах зэрэг 3 төслийг энэхүү санамж бичгийн хавсралтад оруулсан байна. Талуудын тохиролцсон анхны төсөл хэрэгжиж эхлэхэд “Хөрөнгө оруулалт, зураг төслийн хамтарсан төв”-ийг Улаанбаатар хотноо байгуулж ажиллахаар гурван тал санал нэгджээ.<sup>3</sup> Түүхэн ховор боломж тохиож байгааг гүнзгий ухамсарлаж Монголын нутаг дэвсгэр дээр хэрэгжүүлэх томоохон төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг зөв сонгох нь чухал юм. Мөн 3 улсын

<sup>3</sup> Д.Уламбаяр., Геополитикийн орчны өөрчлөлт ба МУ-ын гуравдагч хөршийн бодлогын парадигм, Олон улсын харилцаа сэтгүүл, 2017№1/36, т.92



эдийн засгийн ашиг сонирхолыг уялдуулах нь хамгийн чухлаар тавигдаж байна. Хүч тэнцвэргүй 3 улсын ашиг сонирхлыг тодруулбан авч үзвэл ихээхэн зөрүүтэй байдал харагдана. **Хятадын сонирхол:** Хятадын эдийн засгийн гол төвлөрөл Бээжин, Хэбэй, Хэнань хавьд ногддог. Манай төмөр зам дээр дээрх мужуудтай хамгийн ойр учраас Хятадын аж үйлдэржсэн мужуудыг Оросын байгалийн баялаг төвлөрсөн бүсүүдтэй хямд зардлаар холбох боломжтой. Хил залгаа орших Монголын ордуудаас зэс, төмөр, молибден, гянт болд, цайр зэрэг суурь төмөрлөг, нүүрс, нефть, цахилгаан зэрэг эрчим хүчийг импортлох нь өртгийн хувьд хямд юм. Хятадын дотоодын эдийн засгийн хэрэгцээ, коридортой нягт холбоотой. Учир нь Хятад үйлдвэрлэлийн илүүдэлтэй нь тус улсын үйлдвэрлэлийн хэрэглээ 75% байна. Тиймээс илүүдэл барааг гадаад зах зээл рүү хямдаар гаргах эсвэл өөр улс руу үйлдвэрлэлээ гаргаж, хөгжүүлэх зорилготой.

**Оросын сонирхол:** Хятадаас Европ руу чиглэсэн ачааг Монголын нутгаар тээвэрлэх нөхцөлд Транссибирийн төмөр замын ачаалал нэмэгдэж Оросын талд орох орлогыг нэмэгдүүлэх, ялангуяа “Улаанбаатар” төмөр зам нь Монгол-Оросын хамтарсан аж ахуйн нэгж тул түүний ачааллыг нэмэгдүүлэх нь мөн орлого нэмэгдүүлэхэй холбоотой. Дэд бүтцийн хөгжлөөр дамжуулан <sup>4</sup> Сибирь, Алс Дорнодын хөгжилд түлхэц үзүүлэхэд анхаарч байна. **Монголын сонирхол:** Дэд бүтцийн хөгжил, мөн дамжин өнгөрөх тээврийн таатай орчин бүрдүүлэхэд ихээхэн анхаарч байна. Монгол-Хятад, Монгол-Оросын хоёр талын хүрээнд хэрэгжиж буй тодорхой төслүүд, гэрээ хэлэлцээрийг коридорын ерөнхий хүрээнд хамааруулж уялдаа холбоог хангах хэрэгтэй. Хэдийгээр дээрх төсөл нь Монгол улсын дамжин өнгөрөх тээвэр, Европ зэрэг “гуравдагч хөрш”-ийн орнуудад бараа бүтээгдэхүүн нийлүүлэхэд ихээхэн нөлөө үзүүлж болох боловч нөгөөтэйгүүр маш том сорилт болж байна. Учир нь Монгол улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого нь хөрш орнуудын Монгол улс дахь нөлөөг дипломат арга, хамтын ажиллагаагаар тэнцвэржүүлэх зорилттой боловч энэ төсөл, коридор нь хөрш орнуудын нөлөөг нэмэгдүүлэх нь тодорхой юм.

### **БНХАУ-ын гадаад худалдааны бодлого, гарч буй өөрчлөлт**

БНХАУ нь 1.3 тэрбум давсан хүн амынхаа амьжиргааны түвшнийг дээшлүүлэхийн тулд их хэмжээний орон сууц, зам, гүүрийг барьсаар байна. Энэхүү их бүтээн байгуулалтад шаардлагатай зэс, төмөр, нүүрс, газрын тос, байгалийн хий зэрэг нэн хэрэгцээтэй бүтээгдэхүүнийг гадаадаас их хэмжээгээр худалдаж авах нь тус улсын хувьд маш чухал асуудал юм. Тиймээс ч тус улс ашигт малтмалын нөөц ихтэй гадаад орнуудыг сонирхон, тэдгээр улс оронтой худалдаа эдийн засгийн харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлж байна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд Африкийн орнуудад их хэмжээний хөрөнгө оруулалт хийж, гадаад худалдааны хэмжээгээ нэмэгдүүлж худалдаа, эдийн засгийн харилцаагаа “Худалдаа, эдийн

<sup>4</sup> Бодлогын судалгааны төв. “Гурван улсын эдийн засгийн коридорыг Монгол улсын гео-эдийн засгийн сонирхолтой уялдуулах нь”: Судалгааны бүтээл. Удам соёл. 2017 он. тал 30

засгийн хамтын ажиллагааны бүс” байгуулах хэлбэрээр өргөжүүлэн хөгжүүлж байгаа юм. Ази, Номхон Далайн бүс нутгийн аж үйлдвэржилт, эдийн засгийн хөгжилтэй холбоотойгоор дэлхийн зах зээлд Ази тив, тэр дундаа БНХАУ-ын үзүүлэх нөлөө улам бүр нэмэгдэж, уул уурхайн эрдэс бүтээгдэхүүний гол хэрэглэгч хэвээр байна гэж олон улсын шинжээчид дүгнэж байна.

Хятадын Төрийн Зөвлөлийн янз бүрийн хэлтэс болон худалдаатай холбоотой орон нутгийн засаг захиргаанаас боловсруулсан бүх дүрэм журам, норматив баримт бичиг болон бусад бодлогын арга хэмжээ нь олон улсын худалдааны дүрэм, түүний дотор ДХБ-ыг байгуулах Марракешийн хэлэлцээр, Хятад улсын Дэлхийн худалдааны байгууллагад элсэхэд авсан амлалтыг мөрдлөг болгодог.”Хятадын иргэний хуульд хэрэв аливаа Хятад улсын хийсэн олон улсын гэрээ нь Хятад улсын хуулиас ялгаатай тохиолдолд, олон улсын гэрээг баримтлах бөгөөд Хятад улсын аливаа хууль, Хятад улсын үйлдсэн олон улсын гэрээнд алинд ч заагаагүй тохиолдолд олон улсын практикийг баримтлана гэж заасан байдаг. Хятадын Худалдааны яамны гол үүрэг нь дотоод болон гадаад худалдаа, олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн стратеги, хууль дүрэм боловсруулах, гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой нийтлэг ажлыг удирдан чиглүүлэх; гадаадын хөрөнгө оруулалтын бодлого, шинэчлэлийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхэд оршино. Хөдөө аж ахуй, Байгаль орчны хамгаалал, Санхүү, Үйлдвэрлэл, Мэдээллийн технологи, Тээврийн яамдууд холбогдох ажлын хүрээнд худалдааны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцдог. 2018 оны 3-р сарын 17-нд XIII Үндэсний Ардын Конгрессоор Төрийн Зөвлөлийн бүтэц зохион байгуулалтыг дахин шинэчлэхээр баталсан. Төлөвлөгөөнд:

- Байгалийн нөөцийн яам, Экологи, хүрээлэн буй орчны яам, Хөдөө аж ахуйн яам, Соёл, аялал жуулчлалын яам, Үндэсний эрүүл мэндийн комисс байгуулах;
- Шинжлэх ухаан, Технологийн яам, Хууль зүйн яамын бүтцэд өөрчлөлт оруулах;
- Төрийн зөвлөлийн Оюуны өмчийн газар, үндэсний болон орон нутгийн татварын тогтолцоо зэрэг төрийн зөвлөлийн зарим чиг үүргийг өөрчлөн зохион байгуулахаар заасан байна.

Эдийн засаг, нийгмийн хөгжлийн XIII дахь 5 жилийн төлөвлөгөөнд дурдсанчлан Хятад улсын худалдаа, хөрөнгө оруулалтын гол зорилтууд нь: (1) худалдааны оновчтой хувилбарыг сайжруулах, хурдасгах; (2) гадаадын хөрөнгийн ашиглалтыг сайжруулах; (3) гадны хөрөнгө оруулалтын тогтвортой, эрүүл хөгжлийг дэмжих хэмээн тусгажээ.

Олон улсын байгууллагуудын зүгээс хүрэн эдийн засгаас ногоон эдийн засагт шилжихийн тулд юуны өмнө дараах бодлогыг хэрэгжүүлэхийг зөвлөдөг. Үүнд:

- ✓ Ногоон эдийн засгийг дэмжсэн үндэсний стратегийг боловсруулан

хэрэгжүүлэх,

- ✓ Ногоон бизнесийн урамшуулал, хөшүүргийн системийг бий болгох,
- ✓ Олон улсын санхүүгийн болон эрх зүйн орчныг бий болгох,
- ✓ Өндөр хөгжилтэй орнуудын зүгээс худалдаа болон техникийн туслалцаа авах.

НҮБ-аас ногоон эдийн засагт шилжих 10 салбарыг тодорхойлсон. Үүнд үйлдвэр, аялал жуулчлал, хог хаягдлын менежмент, усны менежмент, барилга, тээвэр, сэргээгдэх эрчим хүч, загас агнуур, хөдөө аж ахуй, ойн салбарууд орох бөгөөд ДНБ-ий дор хаяж хоёр хувийн хөрөнгө оруулалтыг эдгээр салбарт зарцуулахад агаар дахь нүүрс хүчлийн хэмжээг бууруулсан, нөөцийн хэмнэлттэй эдийн засагт шилжинэ гэж НҮБ-ын тайланд тусгажээ.

БНХАУ 2016-2020 онд хэрэгжүүлэх XIII 5 жилийн төлөвлөгөө гаргахдаа ногоон эдийн засгийг хөгжүүлэх нь стратегийн бодлогын үндсэн чиглэл, хөгжлийн суурь хэмээн толорхойлсон. БНХАУ-ын XIII-р 5 жилийн төлөвлөгөөнд экологийн салбарт байгаль орчныг хамгаалан сэргээх, байгалийн баялгийг хэмнэх, эргүүлэн ашиглах, уул, ус, ой, газар тариалангийн болон нуур, цөөрмийн экологийн орчинг хамгаалах тухай 20 гаруй төсөл багтсан байна. Мөн 666 мянган га бохирдсон тариалангийн талбайг засан сайжруулж, 2.7 сая га бохирдолд өртсөн тариалангийн газрын эрсдэлийг тогтоон барих, цацраг идэвх хаягдал бодисыг шийдвэрлэх төвүүдийг байгуулах, намагтай талбайг 53.3 сая га-гаас дээш хэмжээнд байлгах зэрэг зорилт тавьсан байна. Хятадын эдийн засгийн өсөлтөд ихээхэн хувь нэмэр оруулдаг үйлдвэр, цахилгаан станцууд агаар, ус, хөрсийг ихээр бохирдуулж яаралтай арга хэмжээ авахгүй бол Хятадын нийгэм эдийн засагт томоохон хохирол үзүүлэхүйц болсон учир Хятадын засгийн газар бохирдлын эсрэг хэд хэдэн арга хэмжээг авч эхлээд байна. Үүнд:

- **Бага нүүрс, эрүүл агаар:** Хятадын засгийн газар нүүрс ашигладаг цахилгаан станцуудыг багасгах талаар шат дараалалтай арга хэмжээ авч утаа ялгаралын хэмжээг мэдэгдэхүйц бууруулсан. Үүний дүнд Хятадын томоохон хотуудын агаарын орчин эрс сайжирсан.
- **Илүү оновчтой дүрэм журам:** Хуучин Хүрээлэн буй орчин хамгааллын яамыг шинээр Экологи, хүрээлэн буй орчны яам болгон шинэчилж илүү өргөн хүрээтэй, тодорхой зорилготойгоор ажиллаж эхэлсэн. Энэхүү шинэ зохион байгуулалт нь өмнө нь бусад яамдуудын хэлтэст хуваагдан явагдаж байсан ажлуудыг нэгтгэн авч үзэх юм.
- **Ногоон ирээдүйд хөрөнгө оруулах нь:** Хятад улс ногоон эдийн засагт шилжихэд нэмэлтээр 40-123 тэрбум юаны хөрөнгө оруулалт хэрэгтэй байгаа бөгөөд үүний тулд хүрээлэн буй орчны татварыг цуглуулж эхэлсэн ба байгаль орчинтой холбоотой хөрөнгө оруулалтыг татахаар зорьж байна.

- **Сэргээгдэх эрчим хүч:** Хятад улс сэргээгдэх эрчим хүч, ялангуяа нарны эрчим хүчийг ашиглах салбарт үйл ажиллагаагаа эрчимтэй хөгжүүлж байна. 2020 он гэхэд 150-200 кВт цахилгаан нарны эрчим хүчнээс, 250 кВт цахилгааныг салхины эрчим хүчнээс гаргаж авахаар ажиллаж байна. Сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн санхүүжилтыг цахилгааны үнэ дээр кВт-цаг тутамд 0,019 юан нэмэн гаргахаар тооцоолж байна. Цахилгааны үнэ 2018 оны 4 сарын байдлаар өрх гэрт: 52 юань/ 100 кВт-цаг, аж ахуй нэгж: 81 юань/ 100 кВт-цаг байна.

Хятад улс чөлөөт худалдааны үзэл баримтлалыг идэвхитэй хэрэгжүүлж, олон талт худалдааны системийг тууштай дэмжиж ирсэн ба Хятадын эрх баригчдын мэдээлснээр эдийн засгийн хөгжил нь “Хурднаас чанар луу” гэсэн шинэ шатанд шилжсэн болохыг бөгөөд цаашид зах зээлээ илүү чөлөөлж “илүү нээлттэй, хүртээмжтэй, тэнцвэртэй” хөгжлийг бий болгох зорилготой байна. ДХБ-д элсэн орсноос хойш Хятад улс олон талт худалдааны системийг дэмжиж, худалдааны хөрөнгө оруулалтын либералчлал, хялбаршуулалтыг идэвхтэй дэмжиж, маргаан шийдвэрлэх механизм ба эрх зүйн статусыг үр дүнтэй хадгалах, худалдааны бодлогын хяналтад идэвхтэй оролцож, хөгжиж буй орнуудыг олон талт худалдааны системд оролцохыг бүх талаасаа дэмжиж, нэг талыг баримталсан болон хамгаалах бодлогыг тууштай эсэргүүцэн, олон талт худалдааны тогтолцооны эрх мэдэл, үр дүнтэй ажиллагааг бодитоор хэрэгжүүлж байна.

Монголын экспортын бүтцийг түүхий эдээс боловсруулах чиглэлд боломжийн хэрээр оруулах, тээврийн өртгийг бууруулах, үр ашиг, чанарыг дээшлүүлэх, зах зээлийн мөчлөгийн эрсдлийн менежментийг сайжруулах, хамтын хийгээд хөрөнгө оруулалтын төслүүдэд монголчуудын оролцоог нэмэгдүүлэх зэрэг анхаарал татсан олон асуудлыг шийдэхийн төлөө хоёр улсын төр, засаг идэвхтэй ажиллаж байна. Дээр дурдсан стратеги зорилтын шинжтэй олон зүйлийг үр дүнд хүргэхэд эхний ээлжинд Монголын талаас санал, санаачилга гаргах нь чухал юм. Нөгөө талаар хоёр орны худалдаа, хамтын ажиллагаанд Хятадын өнөөгийн удирдагчид шинэлэг зарчмаар хандаж байна. БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Ван Шяолунийн 2013 оны 5 дугаар сарын 6-ний өдрийн “Өнөөдөр” сонинд өгсөн ярилцлагад “Ши Зиньпин дарга Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболдыг Боагийн чуулганы уулзалтын үед хүлээн авч хэлэхдээ...”**Хамтын ажиллагааны бодит төсөл дээр Монголын талын ашиг сонирхлыг илүү тусгах” болно** гэж хэлснийг онцлоод энэ нь Ши Зиньпин Хятад улсын дарга болсноосоо хойш **сайн эргэцүүлэн бодсоны** дараа илэрхийлсэн байр суурь мөн бөгөөд Хятадын шинэ үеийн удирдлага Монголын талд хийсэн **буурьтай амлалт**” юм гэжээ. “Бид “Нэг бүс, нэг зам” санаачлагыг ашиглан Хятад, Монголын харилцаанд шинэчлэлийг авчрах хэрэгтэй. Үүнээс гадна Хятад улс нь Монголын мал аж ахуйн бүтээгдэхүүн, эрдэс бүтээгдэхүүний экспортыг өргөжүүлэх хүсэл эрмэлзлэлийг Хятад улс анхаарч, Монгол улсыг дамжин өнгөрөх тээвэр, далайн боомтуудын ашиглалтад

дэмжлэг үзүүлэх, таатай нөхцөл бүрдүүлэн ажиллах болно.<sup>5</sup> Өнөөдөр аж үйлдвэр, худалдааны холбоо нь 4.38 сая гаруй гишүүдтэй бөгөөд гол хамтран ажиллах объект нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд юм. Аж үйлдвэр, худалдааны холбооны дэд даргын айлчлалын үр дүнд төлөөлөгчид Монголын хөрөнгө оруулалтын бодлого, хүрээлэн буй орчны талаар илүү гүнзгий ойлголттой болох, Хятад, Монголын аж ахуйн нэгжүүдийн хамтын ажиллагааны боломжийг судлах, эрчим хүч, уул уурхай, дэд бүтцийн салбарт прагматик хамтын ажиллагааг хөгжүүлэхийг зорьж байна.<sup>6</sup> “БНХАУ Монгол Улстай стратегийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, Хятад-Монгол-Оросын эдийн засгийн корридор, Хятад-Монголын чөлөөт худалдааны бүс, БНХАУ-Монголын хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг эрчимжүүлэх, Худалдааг хөнгөвчлөх, гол гол төслүүдийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, хоёр талын эдийн засаг, худалдааны салбарын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, Хятад-Монголын эдийн засаг, худалдааны харилцааг тогтвортой хөгжүүлэхэд хамтран ажиллахад таатай байна.<sup>7</sup> Өнгөрсөн хугацаанд бид эдийн засгийн өсөлтөд хүрэхдээ газар, нөөц, хөдөлмөр болон бусад хүчин зүйлсээс хамаардаг байсан харин ирээдүйд хөгжингүй орнуудын хөгжлийн туршлага болох эдийн засгийн хөгжилд түлхэц үзүүлэх шинэлэг технологид тулгуурлах ёстой. Бид инноваци, хөгжлийг чухалчилж авч үзэх болно<sup>8</sup> Бид байгалиас заяасан байгалийн нөөцөөс бус, байгалийг хүндэтгэн хамгаалахыг эрмэлзэх төдийгүй байгаль, хүний зэрэгцэн орших таатай нөхцлийг бүрдүүлнэ. Үүнтэй холбогдуулан Хятад улс илүү ноцтой нөхцөл байдалтай тулгарч байгаа бөгөөд илүү эрчимтэй арга хэмжээ авах болно.<sup>9</sup> Говь сүлжмэл цамцны үйлдвэрт айлчлах үедээ дэд дарга Янь Жүнчи хэлэхдээ “Сүүлийн жилүүдэд ноолуурын үйлдвэрлэл хурдацтай хөгжиж, Монголын эдийн засгийн хөгжлийн онцлог давуу тал болж байна. Хятад, Монгол хоёр газар зүйн байршлын хувьд хөрш зэргэлдээ, хоёр талын харилцан ашигтай хамтын ажиллагаа нь тохиромжтой нөхцөлтэй байдаг. Хоёр тал хамтын хөгжил цэцэглэлт, хөгжил дэвшилд хүрэхийн тулд төрөл бүрийн салбарын хамтын ажиллагааг бэхжүүлэх болно гэдэгт найдаж байна<sup>10</sup> хэмээжээ. Хятад, Монгол хоёр орон газар зүйн байршлын хувьд хөрш, эдийн засгийн хувьд харилцан нөхөх шинжтэй. Хятадын талд зах зээл, хөрөнгө мөнгө, техник технологи, зам, дэд бүтцийн талаар давуу тал бий. Монгол Улс арвин их байгалийн баялагтай. Иймд хоёр тал хамтран ажиллахад ихээхэн боломж байна.<sup>11</sup> Хоёр тал уул уурхайн бүтээгдэхүүнийг гүнзгий боловсруулах, шинэ эрчим хүч, хөдөө аж ахуй, мал аж ахуй, байгаль орчныг хамгаалах зэрэг салбарт бүх талын хамтын ажиллагаа явуулах

<sup>5</sup> Гадаад хэргийн сайд Ван И – 2018 оны 8-р сард хийсэн айлчлалын үеэр хэлсэн үг

<sup>6</sup> Аж үйлдвэр, худалдааны холбооны дэд дарга Ян Чирү 2016 оны 10-р сард хийсэн айлчлалын үеэр хэлсэн үг

<sup>7</sup> БНХАУ-ын Худалдааны яамны сайд Гао Хучен 2016 оны 5-р сард хийсэн айлчлалын үеэр хэлсэн үг

<sup>8</sup> БХАТХ-ын Байнгын хорооны дэд нарийн бичгийн дарга Шен Чуняо 2015 оны 12-р сард хийсэн айлчлалын үеэр хэлсэн үг

<sup>9</sup> БХАТХ-ын Байнгын хорооны дэд нарийн бичгийн дарга Шен Чуняо 2015 оны 12-р сард хийсэн айлчлалын үеэр хэлсэн үг

<sup>10</sup> БХАТХ-н Байнгын хорооны дэд дарга Янь Жүнчи 2015 оны 11-р сард хийсэн айлчлалын үеэр хэлсэн үг

<sup>11</sup> БНХАУ-ын дарга Ши Жинпин 2014 оны 08-р сард хийсэн айлчлалын үеэр хэлсэн үг

болно. Эдгээр шинэ хэлбэрийн хамтын ажиллагаа нь хоёр орны ард түмэнд улам их, бодит ашиг тус авчирна гэдэгт найдаж байна.<sup>12</sup> БНХАУ-ын шинэчлэл өөрчлөлт, нээлттэй байх бодлого, орчин үеийн бүтээн байгуулалт нь хөрш орнуудад, түүний дотор Монгол улсын хөгжилд нааштайгаар нөлөөлж, чухал түлхэц болно. Хятад, Монгол хоёр улсын хөгжлийн стратегийг үр дүнтэй хослуулснаар хамтран хөгжих бүрэн боломжтой юм.<sup>13</sup> Азийн улс орнууд хамтдаа хүчирхэгжин, харилцан туслах ази чанараа хадгалан, давуу талаараа харилцан нөхөлцөж, эрх ашгаа хамтатган өргөжүүлж, чөлөөт худалдааны бүс байгуулах болон харилцан дэд бүтцээр холбох бүтээн байгуулалтаа урагшлуулан, бүс нутгийн эдийн засгийн интеграцийг гүнзгийрүүлж, хамтдаа хөгжин, нийтлэг эрх ашгийн том бялууг бүтээлцэж, улс орнуудын ард түмний аз жаргалыг нэмэгдүүлэхийг хүсч байна<sup>14</sup> хэмээн Хятадын төрийн албан тушаалтнуудын хэлсэн нааштай хандлагыг зөв тусгаж авах нь чухал юм. Энэ нь өнөөгийн хоёр улсын харилцааны түвшинг шинэ шатанд аваачих, харилцан ойлголцох гол боломж юм.

### **БНХАУ-ын худалдааны хэлэлцээрүүд:**

#### ***а/ Чөлөөт худалдааны хэлэлцээр***

Хятадын эрх баригчдын үзэж буйгаар чөлөөт худалдааны хэлэлцээрийн тоог нэмэгдүүлэх нь худалдааг чөлөөлөх бодлогын гол элемент бөгөөд 2002 оноос хойш нийт 15 улс, бүс нутагтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулаад байна. Хятадын гаалийн ерөнхий удирдлагын газраас мэдээлснээр, 2016 онд нийт гадаад худалдааны 38.8 хувийг чөлөөт худалдааны хэлэлцээрийн түнш улсуудтай (Тайван, Хонконг, Макао-г оруулсан) хийсэн ба нийт 42,2 тэрбум юаныг гаалийн татвараас чөлөөлсөн байна. Хятадын засгийн газрын үзэж буйгаар чөлөөт худалдааны хэлэлцээр нь дотоодын шинэчлэл хөгжлийг хурдасгах, олон улсын эдийн засагтай нэгдэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон талт худалдааны системийг дэмжих чухал арга хэмээн үзэж байгаагаа мэдэгдсэн байна.

<sup>12</sup> БНХАУ-ын дарга Ши Жинпин 2014 оны 08-р сард хийсэн айлчлалын үеэр хэлсэн үг

<sup>13</sup> БНХАУ-ын дарга Ши Жинпин 2014 оны 08-р сард хийсэн айлчлалын үеэр хэлсэн үг

<sup>14</sup> БНХАУ-ын дарга Ши Жинпин 2014 оны 08-р сард хийсэн айлчлалын үеэр хэлсэн үг

Хэлэлцээр байгуулсан улсууд	Хэлэлцээрийн шатанд яваа улсууд	Хэлэлцээр хийхээр судалж буй улсууд
1. Малдив 2. Гүрж 3. Австрали 4. Өмнөд Солонгос 5. Швейцарь 6. Исланд 7. Коста Рика 8. Перу 9. Сингапур 10. Шинэ Зеланд 11. Чили 12. Пакистан 13. АСЕАН 14. Хонконг 15. Макао 16. АСЕАН шинэчлэгдсэн 17. Чили шинэчлэгдсэн 18. Сингапур шинэчлэгдсэн	1. Бүс нутгийн иж бүрэн эдийн засгийн түншлэл (RCEP) 2. Gulf cooperation council (GCC) 3. Япон- Солонгос 4. Шри Ланк 5. Израиль 6. Норвеги 7. Пакистан, хоёр дахь шат 8. Шинэ Зеланд, шинэчлэл 9. Маврик (Mauritius) 10. Молдав 11. Панама 12. Өмнөд Солонгос, хоёр дахь шат 13. Палестин 14. Перу	1. Колумб 2. Фижи 3. Балба 4. Папуа шинэ Гвиней 5. Канад 6. Бенгаль 7. Монгол 8. Швейцарь, шинэчлэл

***б/ Татваргүй, квотгүй бараа оруулах нөхцөл (Duty free quota free access)***

2017 оны 7-р сарын байдлаар Хятад улсруу татваргүй, квотгүй бараа оруулах эрхтэй улсууд:

1. Нигер	1. Коморос	1. Танзани	1. Экваторын Гвиней
2. Сомали	2. Либер	2. Того	2. Ангол
3. Этиоп	3. Мадагаскар	3. Уганда	3. Сенегал
4. Бенин	4. Мали	4. Замбия	4. Афганистан
5. Бурунди	5. Малави	5. Лесото	5. Балба
6. Эритриа	6. Мауритан	6. Чад	6. Мьянмар
7. Жибуут	7. Мозамбик	7. Төв Африкийн бүгд найрамдах улс	7. Камбож
8. Конго	8. Сьерра-Леон	8. Тимор-лест	8. Бангладеш
9. Гвиней	9. Судан	9. Иемен	9. Гамби улс
10. ГвинБуис	10. Өмнөд Судан	10. Вануату	10. Сао Том Принц

Азийн хөгжиж буй орнууд энэхүү жагсаалтад орсон нь сонирхол татаж байна. Манай улс энэ хөнгөлөлтийн нөхцлийг ашиглахад анхаарах шаардлагатай. Хятад улс нэн буурай хөгжилтэй орнуудад татвараас чөлөөлөх боломжийг олгосоор байгаа бөгөөд 2017 оны сүүл гэхэд нийт улсуудын 36 нь нийт тарифийн 97%, 3 нь 94%, үлдсэн 1 нь 61% хувиас чөлөөлөгдсөн байна. 2017 оны 1 сард Самао, 6-р сард Экваторын Гвиней улсуудын гэрээ дуусч уг нөхцлөөс хасагдсан бөгөөд Гамби, Сао

Том Принц улсууд уг нөхцөлд хамрагдаж эхэлсэн байна.

**Монгол улсаас Хятадад экспортлох боломжтой  
бүтээгдэхүүнүүдийн татвар:**

Д/д	Бүтээгдэхүүний нэр	MFN татвар
1	Коксжсон нүүрс	5%
2	Зэс утас	4%
3	Арьсан хувцас хэрэглэл	10%
4	Ноолуур	9%
5	Ноолууран хувцас	14%
6	Нэхмэл эдлэл	8%

**Хятадын гаалийн татвар, төрлүүд:**

- 1. Тарифын квотын хэмжээ** (Tariff rate quota): 2017 оны байдлаар цагаан будаа, улаан буудай, химийн бордоо, ноос, хөвөн, чихрийн нишингэ зэрэг 47 төрлийн бараанд уг татварыг ноогдуулсан байна. Татварын хэмжээ нь Ad valorem буюу хэмжээнээс хамаарна.
- 2. Татах хувь** (Bound rate): Дэлхийн худалдааны байгууллагад нэгдэхээс өмнө Хятадын татварын хэмжээ хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдэд 0-65%, хөдөө аж ахуйн бус бүтээгдэхүүнүүдэд 0-50% хэмжээтэй байсан бол одоогоор дундаж bound rate нь 9,8% (ХАА бүтээгдэхүүнд 15.1%, ХАА бус бүтээгдэхүүнд 9%) байна.
- 3. Хөнгөлөлттэй татвар** (Preferential tariff): Хятад улс хоёр талт болон бүс нутгийн хэлэлцээрийн үндсэнд хөнгөлөлттэй татварыг ноогдуулдаг. Чили болон Шинэ Зеландад ноогдуулдаг дундаж татвар хамгийн бага хэмжээтэй байдаг бөгөөд энэ хоёр улсын араас Коста Рика, Исланд болон АСЕАН-ны улсууд орж байна.

**Татварын хөнгөлөлт ба чөлөөлөлт:** Дараах импортын бүтээгдэхүүнүүд нь татвараас чөлөөлөгдөнө:

1. Нэг ачилтанд байгаа 50 юаниас бага татвартай бараа
2. Сурталчилгааны материал болон туршилтын загварын бүтээгдэхүүн
3. Олон улсын байгууллага болон өөр улсын засгийн газраас ирүүлсэн тусламжийн бүтээгдэхүүн
4. Гаальд бүртгэгдэхээс өмнө эвдэрч гэмтсэн бүтээгдэхүүн
5. Хятадаар транзит хийж буй онгоцны түлш
6. Өдөрт нэг хүнд ноогдох хэрэглээ 8000 юаниас бага, өдөр тутмын



### бүтээгдэхүүн

Үүнээс гадна Төрийн зөвлөлөөс гаргасан дүрмийн дагуу тодорхой хугацаа заах эсвэл тодорхой газарт импортоор орж ирж буй бүтээгдэхүүнд татварын хөнгөлөлтийг үзүүлэх боломжтой байдаг. Хятадын засгийн газар Дэлхийн худалдааны байгууллагад нэгдсэнээсээ хойш амлалтын дагуу алхам алхмаар гаалын татвараа бууруулсаар байна. 2010 он гэхэд дундаж татвараа 15,3%-аас 9.8% болтол бууруулсан байна. Шинхуа агентлагын мэдээлснээр 7-р сарын 1-ээс эхлэн 1449 барааны үндэсний тааламжтай нөхцлөөр (MNF) татварыг 15,7%-аас 6.9% болгон бууруулсан байна. Энэ татвар нь ДХБ-ийн гишүүн орнуудын бараа бүтээгдэхүүнд ноогдуулдаг татвар билээ. Төрийн зөвлөлөөс өдөр дутмын бараа бүтээгдэхүүний татвараа үе шаттайгаар бууруулахаа мэдээлсэн. Хувцас, гутал, малгай, гал тогооны хэрэгсэл, спортын фитнесийг хэрэгслүүдийн татвар 15,9%-аас 7,1%, угаалгын машин, хөргөгч зэрэг гэр ахуйн бүтээгдэхүүний татвар 20,5%-аас 8% болтол бууруулахаар болсон байна. Энгийн дундаж MFN татвар нь 2017 оны байдлаар 9,3% байгаа нь 2013, 2015 онуудтай харьцуулахад ялимгүй багассан. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дундаж татвар 14,6%, бусад бүтээгдэхүүний дундаж татвар 8.5%-тай байна. Импортоор орж ирж буй бүтээгдэхүүний 10% нь татваргүй байна. Бүтээгдэхүүний нэмэн өртгийн татвар (VAT) нь хоёр төрлийн үнэлгээтэй: 11% (2017 оны 7-р сард 13% байсан) ба 17%. Мөн хүний эрүүл мэнд, нийгэм, байгаль орчинд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүн, өндөр зэрэглэлийн, цахилгаан их зарцуулдаг бүтээгдэхүүн, сэргээгдэх дахин ашиглах боломжгүй газрын тосны бүтээгдэхүүнүүдэд хэрэглээний татварыг (consumption tax) ноогдуулдаг. 2015 оноос гоо сайхны бүтээгдэхүүн болон өндөр үнэтэй машинд ноогдуулах татварын хэмжээ нэмэгдсэн.

### Евразийн эдийн засгийн холбоо ба Монголын тухайд:

ЕАЭЗХ нь гишүүн орнуудынхаа хооронд **нэгд**, барааг гааль, тооны хязгааргүй чөлөөтэй солилцх, **хоёрт**, хил, гааль, тээврийн зэрэг үйлчилгээг хялбарчлах, **гуравдугаарт**, капитал-хөрөнгийн оролт, гаралтыг либералчлах **дөрөвдүгээрт**, ажиллах хүчний хөдөлгөөнийг чөлөөтэй байлгах баталгааг хангах үндсэн зорилготой гэж ойлгож байна. Тус холбооны бас нэг чухал чиглэл нь хэлэлцээрээр тодорхойлсон эсхүл тус холбооноос бусад орнуудтай байгуулсан хэлэлцээрээр тохирсон эдийн засгийн зарим салбар-секторуудын зохицуулалт, ижилсгэн хялбарчлах (харилцан нийцүүлэлт) хийх улмаар нэгдмэл бодлого явуулахад оршино. Өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, хамтын ажиллагааг дэмжих, эдийн засгийн хөгжлийг дэмжих үндсэн дээр гишүүн орнуудын ард түмнүүдийн амьдралын түвшинг дээшлүүлэх бодлогын зорилттой хэмээн тунхаглаж байна. ЕАЭЗХ нь дэлхийн хэмжээнд эрчим хүч, түүхий эд, зэвсгийн аж үйлдвэр, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны гол тоглогч юм. Эрчим хүч үйлдвэрлэлийн хэмжээгээр ОХУ дэлхийд 3 дугаар байр эзэлдэг. Цахилгааны эрчим хүчний 44,9 хувь нь нүүрснээс, 26.5 хувь нефть, 15,8 хувь байгалийн хий, 19 хувь

усан цахилгаан станц, атомын станц 15 хувийг тус тус эзэлдэг. Авто болон төмөр зам, цахилгаан эрчим хүчний болон шилэн кабелийн сүлжээгээр өөр хоорондоо болон түнш орнуудтай холбогдох чиглэлээр ихээхэн боломж, зорилт агуулсан зах зээл болно.

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо хоорондын хамтын ажиллагаа 2015 онд Санамж бичиг байгуулснаар эхэлсэн. ЕАЭЗХ-той “Чөлөөт худалдааны хэлэлцээр” байгуулах нь Монгол Улс болон тус холбооны гишүүн улс хоорондын худалдаан дахь тариф болон тарифын бус хориг саадыг арилгах, **монголын уламжлалт экспортын бараа, бүтээгдэхүүний гадаад зах зээлийг тэлэх**, худалдаа, үйлчилгээний хэмжээг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг татахад чухал ач холбогдолтой байна. ЕАЭЗХ байгуулагдсанаар гурван улсын гааль хоорондоо нээлттэй болж, 180 сая хүн амтай, гишүүн улсуудын нутаг дэвсгэрт эдийн засгийн хөгжлийн хүчирхэг шинэ төв, нэгдсэн зах зээл буй болж байгаа юм. Энэхүү холбоонд улс орнууд гишүүн болж орох нь нээлттэй бөгөөд Монгол улсын хувьд ч өргөн боломж буй талаар ОХУ-ын элчин сайд И.К.Азизов онцлов. 2016 онд эм, анагаах ухааны бүтээгдэхүүний нэгдсэн зах зээл буй болов. Ингэхдээ тэдний зүгээс эхний ээлжинд мах, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг Евразийн холбооны орнууд (ОХУ, Казакстан, Белорусс, Киргиз, Армяни)-д чөлөөтэй оруулах асуудлаас эхлэх зүйтэй гэсэн санаа цухалзуулж байгаа юм.

Монгол Улсын Засгийн газар, Евразийн эдийн засгийн Комисс хоорондын Хамтын ажиллагааны ажлын хэсгийн анхдугаар хуралдаан 2015 оны 11 дүгээр сард Улаанбаатар хотноо, хоёрдугаар хуралдаан 2016 оны 11 дүгээр сард Москва хотноо тус тус амжилттай зохион байгуулагдаад байна. Эдгээр хуралдаанаар Монгол улс болон ЕАЭЗХ-ны гишүүн улс хоорондын худалдаа, эдийн засгийн харилцаанд тулгарч буй тариф болон тарифын бус саад тотгорыг бууруулах, худалдааны бодлогыг харилцан уялдуулах, төрийн болон бизнесийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, мал эмнэлэг, ургамал, хорио цээр болон техникийн зохицуулалтын уялдаа холбоог хангах, Монголын бараа, бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг ЕАЭЗХ-ны гишүүн улсад зохион байгуулах зэрэг асуудлыг авч хэлэлцсэн байна. Евразийн эдийн засгийн комиссын сайд В.Н.Корешков Монгол Улсад 2017 оны 3 дугаар сарын сүүлчээр ажлын айлчлал хийж, энэ үеэр Стандарт, хэмжилзүйн газрын удирдлагатай уулзалт хийжээ. Уулзалтын гол зорилго нь “Чөлөөт худалдааны хэлэлцээр” байгуулахын тулд эхний ээлжинд хоёр талын стандарт болон техникийн зохицуулалтын баримт бичгийг судлах шаардлагатай. Мөн хоёр талын стандарт, техникийн зохицуулалтын баримт бичгийг ижилтгэх, худалдаанд саад учруулж буй баримт бичгийн хязгаарлалтын тодорхой нөхцлүүдийг талууд зөвшилцөн нэг техникийн баримт бичиг, нэг тохирлын үнэлгээг худалдаанд хэрэглэхээр тохиролцсон байна. Стандарт, хэмжилзүйн газар Евразийн эдийн засгийн комисстой хамтын ажиллагааны санамж бичиг байгуулснаар хоёр талын харилцан нийлүүлж буй бараа, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд техникийн баримт бичгээс шалтгаалсан хориг хязгаарлалтыг багасгах, цаашлаад “Үндэсний

чанарын хөтөлбөр”-т тусгагдсан экспортын гол нэрийн бүтээгдэхүүн болох мах, сүү, арьс шир, чацаргана, зөгийн балыг гадаад зах зээлд гаргахад түлхэц болж буй чухал үүргийг гүйцэтгэх ажээ. Худалдааг хөнгөвчлөх суурь болсон стандарт, техникийн баримт бичигт тавих шаардлагыг ижилтгэх, тохирлын үнэлгээний үр дүнг харилцан хүлээн зөвшөөрснөөр бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж буй төрийн бодлого, худалдаа эрхлэх боломж нөхцлийн үндсийг бүрдүүлж өгч байгаа юм.

### **ОХУ-ын худалдааны бодлогод гарч буй өөрчлөлт, хандлага:**

Дэлхий нийтийн өмнө дулаарал, цаг уурын өөрчлөлт, даяаршиж буй дижитал ертөнцөд дасан зохицохоос гадна, олон улсын харилцааны олон туйлт дэлхийн шинэ дэг тогтолцоо төлөвших үйл явцад дасан зохицох тухай асуудал хүчтэй яригдаж байна. ОХУ 20 жилийн хугацаатай хөгжлийн бодлого, стратегидаа ногоон эдийн засагт шилжих талаар тусгасан байна. Энэ нь ирээдүйд нөөц баялгийн ашиглалт, байгаль орчныг хамгаалах бодлого, хууль эрх зүй, татварыг уялдуулсан ерөнхий бодлого юм. 2008-2020 он хүртэлх улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн урт хугацааны үзэл баримтлал, баримт бичгүүдэд ногоон эдийн засгийн нийгэм, байгаль орчны зорилтууд тусгагджээ. Ногоон эдийн засгийн хамгийн чухал зорилго бол эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх нь ОХУ-ын хувьд нэн тэргүүний асуудал юм. Ногоон эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд урт хугацааны дараах баримт бичгүүдэд тусгагдсан байна. Үүнд:

- 2030 он хүртэлх эрчим хүчний нөөц, түүний дотор сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний стратеги;
- 2020 он хүртэл Усны стратеги(2010 он)
- 2013-2020 он хүртэлх хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эд, хүнсний зах зээлийг зохицуулах хөтөлбөр
- 2009-2013 оны “Загасны зорилтот хөтөлбөр” загас агнуурын цогцолбор нөөцийн ашиглалтыг сайжруулах, үр ашгийг сайжруулах тухай.

Байгаль орчны менежмент, байгаль орчны хамгааллын салбарт одоогоор 6 төрлийн төлбөр, татвар үйлчилж байна. Үүнд:

- 1) Байгаль орчны бохирдлын төлбөр (сөрөг нөлөө);
- 2) Газрын хэвлийг ашиглах төлбөр;
- 3) Ойн санг ашиглах төлбөр;
- 4) Усны татвар, усны нөөц ашигласны төлбөр;
- 5) Амьтны ертөнц, усны биологийн нөөц ашиглалтын төлбөр;
- 6) Газрын татвар;

Ногоон эдийн засагт шилжих чухал чиглэл бол Хөдөө аж ахуйн экологийг сайжруулах хөтөлбөр юм.<sup>15</sup> Байгаль орчны тогтвортой байдлыг хангах үүднээс ногоон эдийн засгийн дараах чиглэлүүдэд анхаарч байна:

- a. НҮБ-ын баримт бичиг, ЭЗХАХБ-ын баримт бичигт заасан “ногоон” эдийн засгийн өсөлт, нүүрстөрөгчийг бага ялгаруулах эдийн засгийн стратеги, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан чиглэлүүд,
- b. Хүн ам болоод байгаль орчны оршин тогтнох хүчин зүйлсийн ач холбогдол,
- c. Хүрээлэн буй орчинд нөлөөгүй өндөр технологи, үйлдвэрлэлийн болон дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх,
- d. Эдийн засаг дахь олборлох салбарын оролцоог бууруулах,
- e. Байгалийн нөөцийн ашиглалтыг эрс сайжруулж, байгалийн нөөцийн зардлын огцом бууралт, үр дүнгийн нэгжийн бохирдлын хэмжээ (байгаль орчны чадавхи, бохирдлын эрчим хүчний үзүүлэлтийг бууруулах), бохирдлыг бууруулах

Хоёр талын худалдааг аль болох түргэн либералчлах, дээрх судалгааны ажил явагдах буюу ОХУ Дэлхийн худалдааны байгууллагад элсэх хүртэлх хугацаанд худалдааны таатай орчин бий болгох үүднээс Монгол, Оросын хооронд “Зарим барааг хөнгөлөлттэй нөхцлөөр харилцан нийлүүлэх тухай” Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулах саналыг Оросын талд тавьсан боловч өдийг хүртэл шийдвэрлэгдээгүй ажээ. ОХУ-тай ЧХХ байгуулсан тохиолдолд гаалийн тарифыг бууруулах, тэглэх хэлцэл хийх бөгөөд энэ талын хууль эрхзүйн актууд болон тарифын шатлал, хувь хэмжээг судлах нь чухал юм. ОХУ-ын гадаад худалдааны бодлогыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн актыг дурдвал:

- ∅ Гадаад худалдааны үйл ажиллагаан дахь төрийн зохицуулалтын тухай хууль, 2003 (*2004, 2005, 2006, 2010, 2011 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан*);
- ∅ Гаалийн зохицуулалтын тухай хууль, 2010 (*2011 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан*);
- ∅ Гаалийн тарифын тухай хууль, 1993 (*1999 оноос жил бүр нэмэлт өөрчлөлт оруулсан*);
- ∅ Гаалийн тарифын хөнгөлөлт үзүүлэх тухай, Гаалийн улсын хорооны тушаал, 2003

“Гадаад худалдааны үйл ажиллагаан дахь төрийн зохицуулалтын тухай” хуулиар тарифийн болон тарифийн бус арга хэрэгслийн ямар төрлийг хэзээ, хэрхэн ашиглаж гадаад худалдааг зохицуулах, “Гаалийн тарифын тухай хууль”-аар гаалийн тарифын шатлал, татварын төрөл, гаалийн үнэлгээ, татварын хөнгөлөлт болон тарифын квотыг заасан юм.

<sup>15</sup> [http://spbftu.ru/site/upload/201511061652\\_Rakovskaja\\_Rusak\\_2015a.pdf](http://spbftu.ru/site/upload/201511061652_Rakovskaja_Rusak_2015a.pdf)

Гаалийн тарифын тухай хууль болон Гаалийн тарифийн хөнгөлөлт үзүүлэх тухай, Гаалийн улсын хорооны тушаалын дагуу ОХУ импортын бараанд ногдуулж буй гаалийн тарифын шатлалыг дараах байдлаар тогтоожээ. Үүнд:

- ∅ Худалдааны нэн таатай нөхцөл олгож буй орнуудаас гарал үүсэлтэй импортын бараанд гаалийн татварын үндсэн тарифыг ногдуулдаг ба энэ нөхцөл олгох 135 орны жагсаалтыг гаргажээ.
- ∅ Нэн таатай нөхцөл олгоогүй орноос гарал үүсэлтэй импортын бараанд гаалийн татварын үндсэн тарифыг 2 дахин нэмж ногдуулдаг.
- ∅ Хөнгөлөлтийн ерөнхий системийн дагуу тусгай хөнгөлөлт олгож байгаа хөгжиж буй орнуудаас гарал үүсэлтэй импортын бараанд гаалийн татварын үндсэн тарифийн 75 хувийг ногдуулдаг бөгөөд хөгжиж буй 104 орон болон хөнгөлөлтөд хамрагдах барааны жагсаалтыг гаргасан.
- ∅ Хөнгөлөлтийн ерөнхий системийн дагуу тусгай хөнгөлөлт олгож байгаа нэн буурай хөгжилтэй орноос гарал үүсэлтэй импортын бараанд гаалийн татвар ногдуулдаггүй бөгөөд 51 орон болон хөнгөлөлтөд хамрагдах барааны жагсаалтыг гаргасан.
- ∅ Тусгаар улсуудын хамтын нийгэмлэг (ТУХН)-ийн болон Евро-Азийн эдийн засгийн нийгэмлэг (ЕАЭЗХН)-ийн орнууд болон Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан орноос гарал үүсэлтэй импортын бараанд гаалийн татвар ногдуулдаггүй.
- ∅ ОХУ, Беларусь, Казакстан улсууд гаалийн холбоо байгуулснаар хоорондоо гаалийн татвараа тэглэж, гуравдагч орнуудтай хийх гадаад худалдаанд гаалийн нэгдсэн бодлого явуулах болсонтой холбогдуулан “ОХУ-ын гаалийн зохицуулалтын тухай” хуулийг баталж, 2010 оны 7 дугаар сарын 1-ээс хүчин төгөлдөр үйлчилж байна.

ОХУ-ын Засгийн газар гаалийн тариф болон гаалийн нутаг дэвсгэрийн хүрээнд тус орны худалдааны бодлогыг хэрэгжүүлэхэд тарифийн хөнгөлөлтийг зарим төрлийн бараанд тогтоох эрхтэй байдаг. Монгол улс нэн тааламжтай нөхцөл (MFN) болон хөнгөлөлтийн ерөнхий системийн (GSP) дагуу тусгай хөнгөлөлт олгох хөгжиж буй орны жагсаалтад багтаж байна. “Беларусь, Казахстан, ОХУ-ын гаалийн холбооны нэгдсэн гааль, тарифын зохицуулалтын тухай” Гаалийн холбооны комиссын 2009 оны 11 сарын 27-ны өдрийн 130 тоот тушаалын хоёрдугаар хавсралтаар “Гаалийн холбооны тарифын хөнгөлөлтийн тогтолцоог ашиглах хөгжиж буй орнуудын жагсаалт”-ыг баталж, энэхүү жагсаалтад 103 орон багтсанаас Монгол улс 60-д бичигдсэн байна. Мөн тушаалын гуравдугаар хавсралтаар “Хөгжиж буй болон бага хөгжилтэй орнуудад үйлдвэрлэж, оруулж буй тарифын хөнгөлөлт үзүүлэх барааны жагсаалт”-д манай оронд үйлдвэрлэдэг мах, малын дайвар бүтээгдэхүүн (02), бусад хэсэгт нэрлэгдээгүй буюу тусгагдаагүй

мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүн (05), махан бэлэн бүтээгдэхүүн (16), баяжмал (26), самнаагүй ноос (5101) зэрэг бүтээгдэхүүн дурдагдсан байна. Монгол Улсаас ОХУ-руу экспортолж буй гол нэрийн барааны импортын гаалийн татвар дараахь хүснэгтэд<sup>16</sup> үзүүлсэн байна.

**Монгол улсын гол нэрийн экспортын барааг ОХУ-д нийлүүлэхэд  
мөрдөгдөж буй гаалийн татварын хувь**

Барааны код	Барааны нэр	Тариф		
		Ердийн	MFN	GSP
2529	Жонш	26	13	-
020220	Үхрийн хөлдүү мах	65	32.5	24.38
020500	Адууны шинэ, хөргөсөн ба хөлдүү мах	50	25	18.75
510121	Сэмлээгүй буюу самнаагүй хонины ноос	10	5	3.75
271600	Цахилгаан эрчим хүч	0	0	0
611012	Сүлжмэл хувцас, эдлэл	20	10	-
270112	Битумжсан нүүрс	5	2.5	-
1602	Мах, дайвар мах болон цусаар хийсэн бусад бэлдмэл, тэдгээрийн лаазалсан бүтээгдэхүүн	50	25	18.75
270119	Чулуун нүүрс	10	5	-
570241	Хивс	40	20	-
220860	Цагаан архи	112.56	56.28	-
630120	Хонины ноосон буюу мал, амьтны нарийн үс, ноосон хөнжил, аяны хөнжил	40	20	-
51	Ноос, мал, амьтны нарийн буюу бүдүүн үс, ноос, хялгас; адууны хялгасан ээрмэл, тэдгээрийн нэхмэл даавуу	10	5	-
220290	Согтууруулах биш бусад ундаа	49.57	24.79	-

Тайлбар: MFN- нэн тааламжтай тариф, GSP-хөнгөлөлтийн ерөнхий системийн дагуу ногдуулж буй тариф

**Монгол улсын худалдааны бодлого, эрх зүйн орчинг шинэчлэх шаардлага:**

Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлж, суурийг нь өргөжүүлэх, ялангуяа зөвхөн уул уурхай гэлтгүй шавхагдашгүй эх үүсвэр болсон мал, аж ахуй, газар тарианлангийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, боловсруулж, экспортод гарахыг урамшуулсан гадаад талын таатай орчин нэн чухал юм. Монголын ажиллагсдын дийлэнх мал аж ахуй газар тариан, тэдгээрээс үүсэлтэй үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний салбарт ажиллаж байна. Бүтээмжтэй, тогтвортой, цалин хөлс

<sup>16</sup> “Монгол улс, ОХУ хоорондын чөлөөт худалдааны хэлэлцээрийн төслийн үндэслэл”, ГХЯ-ны захиалгаар хийгдсэн төслийн тайлан. УБ., 2012. тал.63

сайтай боловсруулах салбар, аж үйлдвэрийг хөгжүүлэх нь Монгол улсад орчин цагийн нийгэм байгуулахад чухал ач холбогдолтой юм. Өнгөрсөн зууны 90-ээд оныг бодвол манай хоёр хөршийн иргэд, аж ахуйн нэгжийн худалдан авах чадвар эрс дээшилсэн, монголчууд ч гадна дотно их аялаж, юм үзсэн, хувийн хэвшлийн мэдрэмж, чадвар нэмэгдэж байна. Тэд олон улсын хийгээд хоёр хөршийн зах зээлд нийцэх брэнд бүтээгдэхүүнийг бага ч гэсэн үйлдвэрлэх оролдлого хийж байна. Гэхдээ өөрийн давуу талдаа түшиглэн, олон улсын зах зээлд борлогдох боломжтой цөөхөн зүйл дээр гол хүчээ тавьж дагнан ажиллах нь чухал гэж бодож байна. Олон зүйл рүү санаархаж, гүйгээд байх хөрөнгө мөнгө, хүн хүчний бололцоо ч байхгүй. Уул уурхайгаас бол нүүрс, зэс, дээр нь мал аж ахуйн түүхий эдийг бүх талаар боловсруулж, олон улсын нэмүү өртгийн сүлжээнд орох явдал гэж ойлгож байгаа. Дотооддоо өөрсдийгээ төмрөөр, эрчим хүчээр, бензинээр, барилгын материалаар, химийн зарим зүйлсээр, бас хүнсээр хангах боломж байгааг дээд зэргээр зөв ашиглах учиртай болно. Энэ бүхэнд хүрэх стратегиа боловсруулж гаргахын тулд гадаад орчноо эхлээд сайжруулахаас эхлэх хэрэгтэй юм. Уг нь өнгөрсөн оны намрын дээд хэмжээний уулзалтуудын үед манай удирдлага хоёр хөршдөө Монголын барааг гаалиас чөлөөлөх асуудлыг тавьсан билээ. Үүнийг шийдүүлж чадвал экспорт, боловсруулах үйлдвэр хөгжих орчин бүрдэнэ.

Манай улсын хувьд ЧХХ байгуулах гэхээсээ илүүтэй гадаад худалдаа, хөрөнгө оруулалтад үлэмж нөлөөтэй өмнөд хөршийн бодлого, эрх зүйн орчны өөрчлөлтийг сайтар судлаж, татварын боломжит таатай хөнгөлөлт, хөтөлбөрүүдийг оновчтой ашиглаж сурах хэрэгтэй байна. Одоогийн байдлаар бидэнд 3 ашиглах боломж байгаа харагдаж байна. Эхний алхам бол Хятад улс тарифын хэмжээгээ бууруулах болсноо дахин зарласан бөгөөд энэ нь 2019 оны 1-р сарын 1-ээс эхлэн 700 гаруй барааны импортын татварыг бууруулах болсон төдийгүй тэнд амьдарч буй хүмүүсийн төлөх ёстой татварын хэмжээг бууруулах болсон нь эдийн засгаа нээлттэй болгох тус улсын бодлогын хүчин чармайлтын илрэл юм. Энэхүү шинэ оноос хэрэгжиж эхлэх 700 нэр төрлийн барааны жагсаалтад манай улсаас экспортлодог 17 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн орсон байна. /хүснэгт/ Өөрөөр хэлбэл 2019 оны турш эдгээр барааны худалдаанд татварын хөнгөлөлт эдлэх боломжтой гэсэн үг юм.

## Хятадын 2019 онд үйлчлэх гадаад худалдааны тарифын хөнгөлөлт

№	Барааны жагсаалт	Нэн тааламжтай тарифын үнэлгээ	2019 оны түр үнэлгээ
118	Кокс болон хагас-кокс	5	0
123	Хүчиллэг давирхай кокс	6	3
302	Сүлжмэл материал, савхи болон бусад материалын бүрдэл хэсгүүд	10	8
350	Жинхэнэ боловсруулагдаагүй, эсвэл хуурай арьсан эдлэл	5	3
379	Оёсон эсвэл нэхсэн ямааны ноолууран цамц	6	5
380	Эрэгтэй ноосон гадуур хувцас	6	5
382	Ноосон пальто, нөмрөг	6	5
384	Эрэгтэй ноосон хослол	8	5
385	Эрэгтэй ноосон хүрэм	6	5
386	Ноосон хослол	8	5
387	Ноосон цамц	6	5
389	Ноосон алчуур, ороолт	6	5
390	Ноолууран алчуур, ороолт	6	5
435	Сайжруулсан утсан зэс билүү хайрга	2	0
439	5PPM-с бага хүчилтөрөгчийн агууламжтай бусад төрлийн сайжруулсан зэс утас	4	2
440	5PPM-с бага хүчилтөрөгчийн агууламжтай ба гаднах диаметр нь 25 мм-ээс бага бусад төрлийн сайжруулсан зэс хоолой	4	2
642	Зэс ороох утас	10	6

[Тэмдэглэгээ 1]: Хэрэв татварын үнэлгээний дунд “#” тэмдэглэгээ байвал тэр нь жилийн эхний хагас (2019 оны 1 сарын 1-ээс 6-р сарын 30) болон сүүлийн хагас (2019 оны 7-р сарын 1-ээс 12-р сарын 31) болно. Оноогдох татварын үнэлгээ.

[Тэмдэглэгээ 2]: Нийлмэл татвар 1: Татварт төлсөн хэмжээ \$7000-с доош /Тайвань: 15%; /Татварт төлсөн хэмжээ \$7000-с дээш/Тайвань: 5%, нэмэлт 4256 юань/Тайвань.

[Тэмдэглэгээ 3]: Нийлмэл татвар 2: Татвар төлсөн хэмжээ нэгж хэмжээ \$5000-с доош, 35%; Татвар төлсөн хэмжээ нэгж хэмжээ \$5000-с дээш: 3%, нэмэлт нэгж бүрт \$9728.

Худалдааны нөхцлөө сайжруулах хоёр дахь алхам бол **Processing Trade**<sup>17</sup> буюу эрдэс баялгийн түүхий эдийг гадагш нь боловсруулалт хийх зорилгоор түр экспортлох тухай байна. Бараг бүх оронд ийм түр экспортод татвар ногдуулдаггүй, харин зам тээвэр, боловсруулалтын зардлаа хариуцдаг байна. Хятад бас тийм

<sup>17</sup> <http://www.china-iprhelpdesk.eu/> дэлгэрүүлж үзнэ үү.



бодлоготой байна. Түр экспортолсон түүхий эдийг 2 жилийн дотор боловсруулаад буцаагаад гаргахад гаалийн татвар авахгүй. Дэлхий Банкны мэдээллээр Хятадын Монголоос авдаг эрдэс баялгийн гаалийн татвар ердөө 0.02 хувь байгаа нь бараг байхгүйтэй адил байна.<sup>18</sup>

БНХАУ-ын Худалдааны Яамнаас ААН-үүдийн бүтээгдэхүүн боловсруулах үйл явцыг хөнгөвчилж өгсөн. Эцсийн бүтээгдэхүүн боловсруулахад шаардагдах түүхий эд буюу туслах материал, эд анги, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж зэргийг худалдаж авахад импортын квот болон татвар тарифаас чөлөөлж өгсөн байдаг. Харин уг түүхий эдийг ашиглаж эцсийн бүтээгдэхүүн болгон дотоод зах зээл дээр борлуулахаар импортлоход нь ногдуулаагүй татвар, хураамжийг хойшлуулсан төлбөр хэлбэрээр гаалийн байгууллага хариуцан ногдуулдаг<sup>19</sup> байна.

Энэ худалдааны нөхцөлөөр БНХАУ-ын нутаг дэвсгэр дээрх аж ахуйн нэгжүүдэд угсралт, боловсруулалт хийгдсэн эцсийн бүтээгдэхүүний реэкспорт болон түүхий эд, туслах материал, сэлбэгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн импортлох бизнесийн үйл ажиллагааг хамруулдаг. Хятад улс нь худалдаа хийх процессын системд идэвхтэй оролцож буй улс юм. Энэ системийн хүрээнд худалдаа хийх процесс нь импортын материал, бүрэлдэхүүн хэсгүүдийг тарифаас чөлөөлдөг. Энэ баримт бичиг нь худалдаа хийх процессын эрх зүйн орчин, гаалийн хяналт шалгалт болон татварын орчны давуу талыг тодорхойлсон болно. Манай улс энэ талын зохицуулах механизмыг судлаж, дотоодын бодлого, эрх зүйн орчинд тусгах нь чухал. Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг үндэсний компаниудын үүрэг, оролцоог сайтар тусгах нь чухал юм. Өөрөөр хэлбэл, ОУХХ-д хорших замаар ашиг хүртэх боломж, чадвараа нэмэгдүүлэх талаар эрэл хайгуул хийх хэрэгтэй байна.

Хятад улсын үйлдвэрүүд худалдаа хийх процессыг бүх талаар бүрдүүлж байна. Баталгаат системийн дагуу, боловсруулах үйл ажиллагаа явуулдаг компаниуд импортоор оруулж буй бүх материал, бүрэлдэхүүн хэсгүүдтэй холбоотой импортын татварууд болон тарифын төлбөрийг хойшлуулах эрхтэй байна. Эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортоор оруулж ирж буй материал болон бүрэлдэхүүн хэсгүүд нь импорттой холбоотой татвар болон тарифаас чөлөөлөгдсөн байдаг. Мөн эцсийн бүтээгдэхүүнийг Хятадын зах зээлд борлуулахаар төлөвлөвөл БНХАУ-ын гаалийн байгууллага нь Хятадын зах зээлд борлуулах болсонтой холбоотойгоор хойшлогдсон төлбөр татвар, хураамжийг ногдуулна. Цаашилбал, худалдаа хийх процессийн зорилгод нийцүүлэн гадаадын оролцогч талуудыг оролцуулсан импортлох үйл явц нь үндэсний бодлогын үе шатуудад тодорхойлогдсон бөгөөд нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнд импортоос бусад татвар ногдуулахгүй мөн гаалийн татвараас чөлөөлөхөөр тусгажээ. БНХАУ-д худалдаа хийх процессыг явуулж буй гадаадын олон компаниуд хөдөлмөрийн хөлс, татварын хөнгөлөлтийн нөхцлийг ашиглаж байна. Сүүлийн жилүүдэд

<sup>18</sup> <https://wits.worldbank.org/CountryProfile/en/Country/CHN/Year/2016/TradeFlow/Import/Partner/MNG/Product/all-groups#>

<sup>19</sup> China cuts tariffs on more than 700 goods as it works to open its economy, Bloomberg, Dec. 24, 2018

худалдаа хийх процесс Хятадын эдийн засагт маш чухал үүрэг гүйцэтгэх болсон. Тухайлбал, Хятадын эдийн засагт экспортын худалдаа ойролцоогоор 50% -ийг эзэлдэг. БНХАУ-тай худалдаа хийх нь түүхий эдийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн импортлох бизнесийн үйл ажиллагааг хамруулж байна.

Хятадтай хийх худалдааг гүнзгийрүүлэх гурав дахь алхам бол зэс, цайрын баяжмалын тодорхой хувийг (эхний ээлжинд 10 хувийг) Хятадын үйлдвэрүүдэд хайлуулан бэлэн хийц, хайлш болгон буцаан авч, дотооддоо цахилгаан утас, усны труба, цахилгаан багаж хэрэгсэл, микро процессорын хавтан чийп зэрэг олон бүтээгдэхүүн хийх хүсэлтэй үндэсний үйлдвэрүүдэд түүхий эдтэй болох боломжийг бүрдүүлэх хэрэгтэй байна. Үүний тулд Засгийн газрууд ийм төрлийн худалдааг дэмжиж, баяжмалыг оруулж гаргахад гаалийн болон нэмүү өртгийн татвар (Хятадад энэ татвар өндөр, голчлон 17 хувь) -аас чөлөөлөх шаардлагатай. Зөвхөн хайлах, тунгаах зардлаа төлөөд бэлэн хийц, хайлш авна гэсэн үг. Зэсээр эцсийн бүтээгдэхүүн хийдэг аж ахуйн нэгж манайд нэмэгдэж байгаа юм. Энэ бизнесийн хэлцлийн олон улсын нэр нь “Toll refinery” буюу “Цэвэршүүлэх төлбөр” гэдэг нэртэй хамтын ажиллагааны хэлбэр ажээ. Энэ нь цэвэршүүлэлтийн төлбөр нь металл боловсруулалт, тухайлбал хүдрийн баяжмалын үйлдвэрлэлийн үед харилцан тохирогч талуудад хамаатай бөгөөд металл боловсруулалтын компани цэвэршүүлэлтийн төлбөрийг бүрэн төлөх үүрэгтэй, харин эцсийн бүтээгдэхүүний борлуулалтын нөхцөлд сөрөг үр дагавар үүсвээс гэрээний анхны нөхцлийн дагуу төлбөрийг буцаан олгодог байна. Бизнесийн үндсэн хэсэг нь цэвэршүүлэх юм. Энэ нь 6 платинум бүлгийн материалууд болох платинум, палладин, роди, рутениум, цахиди, осмумум; алт, мөнгийг агуулсан (баяжмал, үлдэгдэл, гоёл чимэглэлийн хаягдал, авто катализатор, электрон хаягдал гэх мэт) материалуудыг боловсруулах, сэргээх, боловсронгуй болгох явдал юм.

Энэ чиглэлийн үйлдвэрүүдийг Гайтенг гэх бөгөөд боловсруулах үйлдвэрийн гэрээнүүд нь хувийн харилцагчдад тохирсон нөхцөл байдлын ямар ч зүйл байхгүй. Үйлчлүүлэгчээс материалын багц бүрийг үйл явцын туршид түүний үндсэн шинж чанарыг хадгалж, улмаар металын нягтлан бодох бүртгэлийн зарчмын үнэн зөв байдлыг хангаж, боловсруулсан материалын бетон бүрт үнэн зөв, нарийн тэнцвэрийг хангаж дангаар нь боловсруулах явдал ажээ. Тус компани олон улсын үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас тоног төхөөрөмжөөр хангуулж, цэвэршүүлэх металлын тооллого, шугам хоолойн санхүүжилтийг хөнгөвчлөх боломжтой болсон байна. Гайтенг боловсруулах төслийн хэрэгслүүд нь зах зээлийг хамгаалж, тогтворгүй байдлыг зохицуулж, өргөн цар хүрээтэй санхүүгийн үйлчилгээг үзүүлдэг. Компани нь металлын үнэ, ханшийн хэлбэлзлийн өртөг, эрсдлийг бууруулах, илүү хурдан боловсруулах, төлбөрийн шугамыг хангаж чаддаг. Мөн түүнчлэн, Гайтенг боловсруулах үйлдвэр нь ямар ч цаг нөхцөлд алтны үнийг тогтоох FX үнийн платформод нээлттэй, эрсдлээс хамгаалалттай байдаг ба USD/ZAR ханшны ашигтай хөрвөлтийн механизмтэй тул тус компани илүү хурдан үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх, төлбөрийн давуу нөхцөлтэй. Төмрийн ханш, арилжааны үнэлгээний

өсөлт болон уналтыг тогтворжуулж, эрсдлийг бууруулах чадамжтай<sup>20</sup> байдаг байна.

## ДҮГНЭЛТ

### Гурван улсын хоорондох гадаад худалдааны эрх зүйн орчинг шинэчлэх

#### 1. Олон талт хамтын ажиллагааны түвшинд:

Монгол улс бол далайд шууд гарах гарцгүй, олон улсын хэмжээнд гадаад тээвэрлэлтийн зардлын түвшингээр хамгийн өндөртэйд тооцогддог орнуудын нэг бөгөөд тээвэрлэлтийн өндөр өртөг зардал нь Монголын гаралтай барааны өрсөлдөх чанарыг бууруулж, импортлож буй барааны үнийг өндөрсгөж байдаг. Сүүлийн жилүүдэд статистик мэдээллээс үзэхэд Монгол улсын нийт экспортын 95 орчим % - ийг уул уурхайн болон мал аж ахуйн гаралтай түүхий эд эзэлж байгаа ба үлдэх 5 хүрэхгүй хувийг аж үйлдвэрийн хагас боловсруулсан болон эцсийн боловсруулалт хийсэн бүтээгдэхүүнүүд эзэлдэг. Монгол улсад боловсруулсан ба хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортлох тээврийн нөхцлийг ДГХБО-ын хөнгөлөлт, нөхцлийг оновчтой бүрдүүлж, ашиглах ур чадвараа нэмэгдүүлэх

#### 1. Бүс нутгийн түвшинд:

Хятад-Монгол-ОХУ эдийн засгийн коридорын хүрээнд хамтын ажиллагаагаа эрчимжүүлэхийн зэрэгцээ Евразийн эдийн засгийн Холбооны гишүүн орнуудтай харилцаагаа эрчимжүүлэх нь нэн чухлаар тавигдаж байна. Түнш орнуудын зах зээлд өчүүхэн хувийг эзэлж буй эдгээр бүтээгдэхүүнд зах зээлийг бий болгох зорилгоор ЧХХ-г оролцоно гэвэл энэ нь утга учир багатай болох нь илэрхий байна. Тийм ч учраас АНУ 1990 оны сүүлээр ЧХХ байгуулах асуудлаар Монголын талаас дэвшүүлсэн саналыг хүлээн аваагүй билээ. Худалдааны гол түнш орнуудтай ЧХХ байгуулах нь Монголын гаралтай барааны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх гол арга замуудын нэг мөн боловч эдийн засгийн өнөөгийн бүтэц тогтолцооны ЧХХ байгуулах замаар үйлдвэрлэл экспортоо дэмжих боломж хязгаарлагдмал байна. Тиймээс ЭЗТХ/ ЧХХ байгуулах гэхээсээ илүү бүс нутгийн эдийн засгийн байгууллагуудын үзүүлж буй худалдааны нөхцлүүдийг судлаж, манай улсын нөхцөлд тохирсон хувилбар, стратегийг боловсруулах, ашиглах механизм бүрдүүлэхэд анхаарах

#### 2. Транзит тээврийг хөгжүүлэх асуудалд

Монгол орны хувьд далайд гарцгүйн дээр хоёр хөршийн дунд хавчигдан оршдог нь эдийн засгийн хамгийн таагүй нөхцөл юм. Үндэсний Аюулгүй байдлын үзэл

<sup>20</sup> <https://gautengrefinery.co.za/technical-expertise/services-and-products/toll-refining/>

баримтлалын 3.2.2.5-д “Гадаад худалдааны дамжин өнгөрөх тээврийн нөхцөлөөс хэт хараат байдлыг бууруулж, далайд гарцгүй орны хувьд тээврийн салбарт хөрш орнуудтай хоёр болон гурван талын урт хугацааны, харилцан ашигтай хэлэлцээр байгуулна. Экспортын бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд гаргах далайн боомтуудтай болох, боомт хүртэл тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах, Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх тээврийн эргэлтийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ<sup>21</sup>.” хэмээн заасан нь Монгол Улс далайд гарцгүй, газарзүйн алслагдмал байршилтай зэргээс шалтгаалан агаарын замаас бусад тохиолдолд БНХАУ, ОХУ-ийн газар нутгаар дамжин өнгөрөх шаардлага гарч буй нь бараа бүтээгдэхүүний тээврийн зардал Монгол улсын хувьд бусад хөгжингүй орнуудын тээврийн зардлаас 2 дахин илүү байгаатай холбоотой. Тиймээс дамжин өнгөрөх тээврийн асуудлаар хоёр хөрштэйгээ хамтын ажиллагааг эрчимжүүлж, хүчин чармайлтаа үргэлжлүүлэх шаардлагатай.

Дэд бүтэц нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудын бизнесийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх чадавхийг бэхжүүлэх хүчин зүйл, худалдааны дэмжлэгийг бий болгоход чухал ач холбогдолтой юм. Тийм учраас дэд бүтэц, ялангуяа олон улсын зах зээлээс алслагдсан байдлыг даван туулахын тулд дэд бүтэц, ялангуяа тээвэр (зам, төмөр зам) -ыг дамжин өнгөрөх улсууд болон хөршүүдтэй хамтран боловсруулж, хөгжүүлэх нь чухал юм.

- Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх нь бүтээмжийн хүчин чадал, эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг бий болгох бас нэгэн чухал элемент бөгөөд үйлдвэрлэгч, экспортлогчдын өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлөхгүй өртөг зардалтай байх ёстой.
- Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын хувьд хөрөнгө оруулагчдад тохирсон хугацаанд хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа олгож, холбогдох засгийн газруудад шилжүүлэхийн өмнө дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэх үр ашигтай хувилбаруудыг авч үзэх хэрэгтэй.
- Дэлхийн нэмүү өртгийн сүлжээ нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудад өнөөгийн олон улсын үйлдвэрлэлийн сүлжээний түүхий эд, салбарын онцлогийг ашиглах боломжийг олгож чадна. Энэ нь тэдний бодлого боловсруулах явцад анхаарал хандуулахад хүргэдэг.
- Далайд гарцгүй хөгжиж буй орнууд дэлхийн үнэ цэнийн сүлжээний зарим сегментийг бүрдүүлж, байр сууриа дээшлүүлэхийн тулд тасралтгүй эрэл хайгуул хийх ёстой. Учир нь түүхий эдээс хараат далайд гарцгүй хөгжиж буй орнууд нь өртгийн сүлжээний үнийн доод хязгаарын түвшинд хүрэхэд ихээхэн чармайлт гаргадаг. Жишээлбэл, далайд гарцгүй хөгжиж буй орнуудын экспортыг дэмжих импортыг багасгах, үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд хувийн хэвшлийг татан оролцуулж, хамтран ажиллах нь чухал ач холбогдолтой юм.

- Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын жилийн дундаж өсөлт 6.2 хувьтай байна. Далайд гарцгүй хөгжиж буй орнууд дэлхийн эдийн засагтай холбогдохыг дэмжих замаар транзит хөгжиж буй орнууд илүү их оролцдог талаар Венийн хөтөлбөрийн үйл ажиллагаанд дурдсан байдаг. Харин далайд гарцгүй хөгжиж буй орнууд бусад орнуудтай адил шийдлийг эрэлхийлэх ёстой.

#### **4. Монголын барааг гаалиас чөлөөлөх худалдааны бодлого, эрх зүйн үндэслэл бүрдүүлэх**

Монгол Улс өнөөдөртөө байгалийн баялаг, мал аж ахуйн түүхий эдээ экспортолж байна. Үйлдвэржүүлэлтийн талаар дотооддоо зарим арга хэмжээ авч буйг гадаад орчноор дэмжмээр байна. Монгол Улсын эдийн засаг, түүний дотор Монгол Улс үйлдвэржиж чадах эс чадах нь Монгол Улсын гадаад бодлого хэр зэрэг амьдралд ойрхон байж, нийгмийн амьдралыг дэмжих таатай орчин бүрдүүлэхээс бараг 100 хувь хамааралтай гэж хэлж болно. Гадаад бодлогын амин сүнс болсон гаалийн асуудлыг эхлээд авч үзье. Үйлдвэржихийн тулд бараагаа олон улсын зах зээлд гаалийн татваргүй оруулах нь нэн чухал. Үндэсний эрх ашгийн асуудал бөгөөд үнэт түүхий эд, натурал зүйлсээ нийлүүлж буй орны хувьд зарим хэсгийг боловсруулж гаргахад татваргүй оруулахыг түншээсээ хүсэж ойлгуулах нь чухал юм. Гаальгүйн статусыг Монголд олгох олон улсын эрх зүйн үндэс байна. “Далайд гарцгүй” гэдэг статусын үндсэн агуулга нь дэлхий хамгийн хямдхан тээвэр болох далайгаар бараа тээвэрлэх, далайн ус, баялаг ашиглах боломжгүйг нь харгалзаж, далай бүхий орнууд өөрсдийн нутгаар далайд гарцгүй орнуудын гадаад худалдааны ачаа, тээврийн үйлчилгээг саадгүй явуулах, далай тэнгэсээр усан онгоц явуулах, **гаалийн тарифын хөнгөлөлт** үзүүлэх зэрэг үйлчилгээний олон улсын эрх зүйг бүрдүүлэхэд оршиж байдаг байна.

ДХБ-ын гишүүн ОХУ эсвэл БНХАУ нь Монгол Улсын экспортын барааг өөрсдийн нутаг оруулахад гаалийн татвараас чөлөөлсөн байваас “ДХБ-ын дүрмийг зөрчөөгүй гэж үзэх учиртай. Тухайлбал, ЕХ Монголын ихэнх бараанд гаалийн “тэг” татварын зарчмыг тогтоосон болно. Хөрш орнуудтайгаа харилцааны дээд түвшинд хүрснийг юугаар хэмждгийг бодитоор авч үзэх хэрэгтэй. Тариф болон бусад нөхцлөөр боож хаадаг явдал харилцааны дээд түвшний шинж тэмдэг биш. Нэмүү өртөг шингэх тусам хязгаарлалт нэмэгддэг худалдааны зарчим бий. Үүнийг яаж гэтлэх тухай яриа тул хөршүүдтэйгээ энэ талаар санал солилцож, худалдааг хөнгөвчлөх асуудлаар тодорхой алхам хийх нь Монголын хувьд чухал алхам болоод байна.

### НОМ ЗҮЙ

1. World Trade Statistical Review 2018, [www.wto.org](http://www.wto.org)
2. Joint Staff Working Document: Brussels, 19.1.2018SWD (2018), The EU Special Incentive Arrangement for Sustainable Development and Good Governance (‘GSP+’) assessment of Mongolia covering the period 2016 – 2017
3. А. Нямдолжин, Монгол-Оросын стратегийн түншлэл худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэх хөшүүрэг болох нь, “Стратегийн түншлэл ба Монгол улсын гадаад орчны өөрчлөлт. Өгүүллийн эмхэтгэл”, УБ., 2015, т.3
4. China cuts tariffs on more than 700 goods as it works to open its economy, By BLOOMBERG, DEC24,2018
5. Xue li and Zheng Yuwen “A blueprint for China’s Neighborhood Diplomacy” The Diplomat March 30, 2016
6. Гурван улсын эдийн засгийн коридорыг Монгол улсын геоэдийн засгийн сонирхолтой уялдуулах нь” Бодлогын судалгааны төв. Удам соёл. 2017 он. т. 9
7. Facilitating the Participation of Landlocked Developing Countries in Commodity Value Chains. New York Geneva, 2015. p. 25
8. <https://unctad.org/en/Pages/DITC/GSP/GSP-Preferential-Market-Access.aspx>
9. [https://unctad.org/meetings/en/Presentation/aldc2013\\_wtoBali\\_Odari2\\_en.pdf](https://unctad.org/meetings/en/Presentation/aldc2013_wtoBali_Odari2_en.pdf)
10. <https://mn-nhrc.org/>
11. <https://www.ohchr.org/EN/Countries/AsiaRegion/Pages/MNIndex.aspx>
12. <https://Export.gov/>